

“ХЭВШИЛ ТОГТОЛЦОО БА “ТУНГАЛАГ ТАМИР”

Б.Мөнхбаяр¹

“Уран зохиол урлагийн бүтээлийг судлахдаа ерээд оноос олноо голдуусэдэвчлэн авч тоймлон судалдаг байлаа. Энэ бол судалгааны хэлгийн элементарн (хялбарчилсан) арга. Нөгөө талаар нэг намын үзэл суртлын хүлээсэнд байсан уран зохиол урлагийн хувьд уран сайхны олон хэлбэр маяг хэрэглэж чаддаггүйгээс уран зохиолын задлан шинжилгээг зөвхөн сэдэв, үйл явдлын тойм ... мэтхэний хүрээнд л эргэлдүүлээд байхаас өөр замгүй байв.”²

Гэтэл аливаа урлагийн бүтээл нь тухайн уран бүтээлчийн уран сайхны сэтгэлгээний илэрхийлэл, бодит тодорхойгоос гадна бэлэгдэл хийсвэрлэлийн элементийг агуулсан, бичих туурвих шинэ, шинэ боломжийг эрж туршсан, өвөрмөц хэв төлөвийн содон сонин, этгээд байх тул, нийм нөхцөл байдалд бид судалгааны шинэ арга зүйгээр тэдгээр содон бүтээлд хандах хэрэгцээ, шаардлагатай гарцаагүй тулгарч байгаажум: Энэ үднээс ХХ зууны монголын алдартай нэгэн зохиолд “Formulaic Theory” буюу “Хэвшил тогтолцоо”-ны онол-арга зүйн үүднээс зарим ажиглалт хийхийг зорьлоо.

“Formulaic Theory” буюу “Хэвшил тогтолцоо”

Монгол судлаач Б.Я.Владимирцов (1884-1931) “*Ойрид Монголын баатарлаг тууль*” (1923) бүтээлдээ:

“... Жангар” туулийн бодит баримтат байдал нь нэг талаас олон тооны салагид бүлэг шүлгээс бүрдсэн тэй нь холбоотой бөгөөд ... тэдгээр бүлгүүдэд:

1. *Жангарын ордон харшийн тухай*
2. *Мал ахуй, нутаг орны нь тухай*
3. *Хурим найр, хүүхэд үеийн байдлыг нь*

тод дүрслэн өгүүлэх [бүлэг бүрт эдгээр зүйлийн тухай давтан дүрсэлдэг гэсэн үг Б.М] бөгөөд, иймэрхүү дүрслэл нь Жангарын ялалтын бэлэгдэл дүрслэл болдог. Ийм дүрслэлийг олон улсын хэмжээнд “Commonplace” буюу “Давтагддаг хэллэг” гэж нэрлэдэг бөгөөд,

1. ШУА, Хэл зохиолын хүрээлэн.

1. Ч.Билигсайхан “Монгол хүүрнэл зохиолын өнөө маргааш”, “Уран зохиол судлал”, ШУА, Хэл зохиолын хүрээлэн, УБ, 2004, 40-р тал

Б.Мөнхбаяр

туульд онцын хувиралтгүйгээр олон удаа илэрдэг юм.”³ гэсэн, нэгэн ийм санаа хэлжээ.

Харвардын их сургуулийн дэд профессор Milman Parry (1902-1935) өөрийн шавь Albert Lord (1912-1991) –ийн хамт 1933-1935 онд Серби Хорватын нутгаар хээрийн шинжилгээ хийж, арвин хэрэглэгдэхүүн цуглуулсны эцэст хэдийгээр Milman Parry цаг бусаар нас барсан ч, түүний шавь Albert Lord 1953 онд “Серби Хорватын баатарлаг тууль”⁴, 1960 онд “Туульч”⁵, 1991 онд “Туульч ба аман уламжлал”⁶ зэрэг бүтээл туурвисан ба үүндээ:

“Аливаа туульсын бүтээл нь, туульд гарч буй баатрын өгүүлэмж үйл хэрэг явдлууд олонтаа давтагддаг нь “**нуриусан давталт**” бус, хэвшсэн тогтолцоо бүхий үзэгдэл бөгөөд чадварлаг, авьяаслаг үлгэрч, туульч, дууч нар нь өөртөө хэвшүүлсэн, чухам өөрийн болгосон ямар нэгэн тодорхой хэвшил тогтолцоо бүхий дүрслэл, үйл хэрэг явдал, өгүүлэмж (баатар эрийн мэндлэх, осон торниж буй тухай, байлдааны зэр зэвсэг тоног хэрэгслийн тухай, дайн байлдааны бэлтгэл, цан, хэнгэргийн дуу, уриа, аян дайнд мордохын өмнөх яриа, хоорөө, хүн болон агт морины тухай, аль нэгэн алдартай баатрын тухай, сүй тавьсан гоо авхайн тухай, аль нэгэн хүний нутаг усны тухай хууль цааз, хурим найр, баяр дурсгалын найрын наадмын тухай, баатар эрийн үхэл, оршуулгын ёслол ... бусад янз бүрийн байдал, жишээлбэл: байгалийн сайхан, түүний өнгө үзэмжийн дүрслэл) –дээ тулгуурлан бүтээлээ бий болгодог”⁷ гэсэн санааг дэвшүүлжээ.

Хэдийгээр Б.Я.Владимирцов хэвшил тогтолцооны тухайд тун гярхай ажигласан авч, тухайн үед түүнд зохиол туурвилын энэ мэт үзэгдлийг гүн гүнзгий, тогтолцоотой задлах бололцоо харахан байсангүй. Хэрвээ Б.Я.Владимирцов энэхүү чухал санаагаа туульс бүтээлийн найруулгын төвшинд ойлголтгүй, ерөөс туулийг зохиох, хайлах үндсэн онцлогийн хувьд нь анхаарч, нарийвчлан үзсэн бол туйлын чухал байх байсан юм. Учир нь түүний гаргасан энэхүү тодорхойлолт нь туульсын зохиол бүтээлийн зохион хайлах ёс журам, зүй тогтолтой сайтар нийцдэг билээ. Гэвч “Аливаа бүтээлийн үнэ цэнийг бүтээгдсэн цаг үеийн шалгуураар үнэлбэл үнэнд илүү ойр байдаг” гэсэн зарчмын үүднээс харах юм бол нэг талаар тухайн үе нь “Хэвшил тогтолцоо” (formulaic theory)-ны онол нь дөнгөж үр хөврөлийн шатандаа байсан, нөгөө талаар түүний судалгааны зорилго чиглэл нь өөр байсантай холбоотой болов уу.

Харин Milman Parry, Albert Lord нарын тухайд гэвэл аман уламжлал, түүний харилцаа холбоо, орчин, дамжуулалт, туульчийн туурвил зүйн сэтгэлгээний загвар, хэв маяг, зохиол бүтээлээ хэрхэн, яаж, юунд тулгуурлаж зохиож бүтээдэгийг судлахыг зорьж, аргачлал, арга зүйгээ боловсруулан, тодорхой чиглэлийн хүрээнд ажилласан учир судалгаа нь амжилттай болсон бөгөөд тийм ч учраас судлаачдын дунд “The Parry-Lord theory” буюу “Formulaic Theory” хэмээх алдрыг хүртжээ.

Milman Parry, Albert Lord нарын томъёолж байгаагаар: Хэвшил тогтолцоо гэдэг нь (туулийн хүрээнд тодорхойлсноор) Нэгэн ижил айзмаар нэгдсэн, үндсэн ухагдахууныг илтгэх үндсэн суурь загвар нь болж өгдөг, давталтын шинж бүхий хэвшил тогтсон дүрслэл (Formula) мөн ажээ. Тэгэхээр энэ нь уншигч сонсогч нарт зориулагдсан бус, харин бүтээлч туурвигч нарт өөрт нь зориулагдсан, өөрийнхөө төлөө, өөрөө бий болгосон, туурвил зүйн сэтгэлгээний амин чухал тогтолцоо гэж хэлж болох юм. Ийм тогтолцоо нь уран бүтээлд:

2. Б.Я.Владимирцов, “Ойрад Монголын баатарлаг тууль” Mongolian Studies, Journal Of Mongolian Society, Vo. 8 1983-84. P.17.

3. Albert Lord “Beginning Serbo-Croatian”. The Hague: Mouton & Co., 1958

4. Albert Lord “The Singer of Tales”, Cambridge, MA: Harvard Univ. Press, 1960

5. Albert Lord “Epic Singers and Oral Tradition”, Ithaca, NY: Cornell Univ. Press, 1991

6. Б.Цогжин “Монгол аман туулийн шүдэг зүй”. УБ, 2010, 144-145-р тал

Б.Мөнхбаяр

- Холбоо үгийн төвшинд
- Шүлэг байлаа гэхэд шүлгийн нэг мөрийн төвшинд
- Өгүүлбэрийн төвшинд
- Тодорхой нэгэн эхийн (текстийн) бүтцийн нэгжид (мөчлөг, догол мөр, цогцолбор ... гм)
- Өгүүлэмж үйл хэрэг явдлын төвшинд

давтагдан илэрч болох ажээ. Үндсэн шинж нь:

*"Зохиолч уран бүтээлчийн туурвисан бүтээлийн онцлог шинжийг бүрэн илэрхийлэх гол зүйл нь тэрхүү бүтээлд буй хэвшин тогтсон, давтагдаж буй дүрслэл, өгүүлэмж үйл хэрэг явдал"*⁸

гэсэн санаа бөгөөд нйм өгүүлэмж дүрслэлийн нягтрал (*Formulaic Density*)-аар буюу

- Хэшилт хэллэг, дүрслэл, өгүүлэмж, тогтолцооны ямар байгаагаар нь
- Эдгээр нь ямар эрэмбэ дараалал, журамд яаж орсон байгаагаар нь
- Бусад хэллэг, дүрслэл, өгүүлэмжтэйгээ хэрхэн уялдаж, нэгдэж нийлж, яаж харьцаж байгаагаар нь

тухайн бүтээлийн үүсэл гарал, эх үндэс, чанар чансаа, зохиогч туурвигчийн уран сайхны сэтгэлгээний үндсэн загвар ... зэргийг тогтоох боломжтой гэж үздэг байна.

Formulaic Theory ("The Parry-Lord theory") буюу Хэвшил тогтолцооны онол арга зүйг францын судлаач Joseph J. Duggan⁹, Америкийн судлаач John Miles Foley¹⁰ (1947 – 2012), БНХАУ-ын судлаач Мандах¹¹, Б.Цогжин¹² нарын "эрдэмтэд улам" боловсруулан хөгжүүлсээр байна.

Хэвшил тогтолцоо ба "Тунгалаг тамир"

Энэ хэсэгт "Тунгалаг Тамир" романд хэвшил тогтолцоо болсон нэгэн өгүүлэмжийг сонгон, түүний тогтоц, хэв маяг, нягтралд ажиглалт хийх юм.

Аливаа бичгийн зохиол нь түүнийг туурвигчийн уран сайхны сэтгэлгээний илрэл нь болдог ч, зохиогчийнхоо *"бодлоос үл хамаарч, түүний бүтээсэн дүрийн зан төрх, явдал суудал, замаар явах бөгөөд нэгэнт эхлэн бүтээсэн хэв шинж, зан төрхөө тэр чигээр нь учир зүйн (логик) дарааллын дагуу, амьдралтайгаар үргэлжлүүлэх л зохиолчийн үүрэг"*¹³ нь юм.

7 John Miles Foley (1947 – 2012) *Oral-Formulaic Theory and Research: An Introduction and Annotated Bibliography*. New York, 1985. Орчуулсан Б.Цогжин "Аман шүлэг зүй: Парри-Лордын онол". Б.Цогжин "Монгол аман туулийн шүлэг зүй". УБ, 2010, 60-61-р тал

8 Joseph J. Duggan "The song of Roland". *Formulaic Style and Poetic Craft*. Berkeley 1973

9 John Miles Foley (1947 – 2012) *"Oral-Formulaic Theory and Research": An Introduction and Annotated Bibliography*. New York, 1985. "The Theory of Oral Composition: History and Methodology". Bloomington, 1988 Rpt. 1992. "Traditional Oral Epic: The Odyssey, Beowulf, and the Serbo-Croatian Return Song". Berkeley, 1990 Rpt. 1993. "Immanent Art: From Structure to Meaning in Traditional Oral Epic". Bloomington, 1991 "The Singer of Tales in Performance" Bloomington, 1995 (ed.) "Teaching Oral Traditions". New York, 1988 "Homer's Traditional Art". PennState 1999. "How To Read an Oral Poem". Illinois, (2002)

10. Мандах "Монгол хэлний заншил судлал" БНХАУ, Бээжин хот, 2009.

11. Б.Цогжин "Монгол аман туулийн шүлэг зүй", УБ, 2010.

12. С.Байгалсайхан "Уран зохиол шинжлэлийн удиртгал", УБ, 1995.

Б.Мөнхбаяр

Энэ бол ямар ч зохиол, бичлэгийн явцад хэл дүрслэл, өгүүлэмжийн цувралаар биеллээ олж, “Өгүүлэмж” - “Уламжлал” хоёр нь нэгэн цогц боллоо гэсэн үг юм. Хэрэв ийн нэгдэж чадсан гэмээнэ “Өгүүлэмж” - “Түүнийг бичих” гэсэн хоёр зүйл нь нэг үйл ажиллагааны хоёр өөр тал болсон, “хэлний өвөрмөц орчин” бүхий урлагийн бүтээл болох юм.

Мэргэшсэн шилдэг зохиолчид хэлний орчны давуу талыг төгс ашигладаг. Ингэхдээ зөвхөн уран яруу хээнцэр чамин үг хэллэгээр биш, эгэл энгийн, үгийн утгын оновчтой зөв харьцаа, хэлбэрээр агуулгаа илтгэдэг.

Тэгтэл, өнөөгийн бичгийн уран зохиол судлалын ном бүтээлийг уншихад, хэдийгээр сонирхолтой ч гэсэн, хувь уран бүтээлчийн туурвил зүйн орчин дунд буй болсон сонирхолтой зарим чухал элементүүдийг орхигдуулсан байдаг. Иймээс бид

1. Нэг зохиолч (*Ч.Лодойдамба*)-ийн бичсэн нэгэн бүтээл (“*Тунгалаг Тамир*”)-д буй хэвшил тогтолцоо (*formula*) нь түүний туурвисан бусад бүтээлд ч адилхан илрэх ёстой

2. Тухайн зохиолчийн хэрэглэсэн хэвшил тогтолцоо (*formula*) нь, бусад зохиолчийн туурвисан зүйлд ч адилхан байх ёстой

3. Энэхүү хэвшил тогтолцоо (*formula*) нь зохиогчийн туурвил зүйн үндсэн хэрэглүүрийн нэг мөн

гэсэн зарчмыг гол болгон баримтлан авч үзэв.

“Тунгалаг Тамир” нь нийт 4 бүлэг 89 хэсэгтэй, хэсэг бүрт гардаг (*давтагддаг*) төстэй нэгэн өгүүлэмжтэй (*хэдийгээр зохиолын тодорхой үйл хэрэг явдалтай холбогдон бага зэргийн хувиралттай байгаа ч, энэ нь агуулгын чанартай бус, хэлбэрийн төвилийнх*) юм. Тиймээс энэхүү олонтаа давтагдаж буй өгүүлэмжийг **Хэвшил тогтолцоо** (*formula*) гэж үзэж болно.

Бид сонгосон жишээ өгүүлэмжээ “Уулзалт”¹⁴ гэж нэрлэв. Уулзалтын өгүүлэмж бүр, хүний сэтгэлийг татах увдис, хэл дүрслэлийн яруу чанарын хувьд төгс төгөлдөр. Гэхдээ нэг талаас нь харахад нэгэн ижил загварын, давтагдсан, нуруу мэт ч, ямар бүтэц, зүй тогтлоор хэрхэн яаж зохиолтойгоо холбогдож байна? гэдэг талаасаа нэлээд сонирхолтой.

“Тунгалаг Тамир”-ын гол баатрууд хоорондоо уулзаж буй 45 тохиолдлыг дурдвал:

1. **Хонгор –Төмөр:** (*Хонгор хүү гүйсээр гүн жалганы эхээр гарах гэтэл ёроолд ямир нэгэн дуу гарахад зог тусин зогсож харлаа.*

- Дүү минь гүйгээд ир гэж тэртээ дороос бүдүүн дуутай хүн дуугарав.

- Дүү минь битгий ай. Ах нь нэг ядарсан хүн байна гэж паргисан дуугаар хэлэхэд Хонгор жалга руу орж ойртон очив.

- Ах аа, та хүн үү? гэж толгойгоо далжийлган нүдээ жартайлган ширтэж байгаад асуув.

- Би хүн. Дүү минь хүрээд ир

Тэр бол аргагүй л хүн байлаа. Чингэхдээ хоёр гаргүй хүн хэвтэж байв. Хир хөлсөнд баригдаж ус сахал нь ургаад эрэг мөргөж байгаад гарсан сарлагийн бух шиг болсон тэр хүний нүүрэнд хоёр нүд гялалзах ажээ.

- Эр хүн, эр хүнээсээ айх хэрэггүй гээд тэр хүн инээмсэглэв.)

13. “УУЛЗАЛТ” Уулзах үйлийн үр дүнг заасан нэр, нүүр тулан уулзах нь, нүүр тулан учрах нь” “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”, IV боть, ШУА, Хэл зохиолын хүрээлэн, УБ, 2007

2. **Хуяг –Дорж:** (“Арван цагаан буян чинь дэлгэрч яв” гээд гүйлгачин хадгийг авч нандигнан өвөртлөв, өндөр хээр морьтой орос ланчуу буу үүрсэн хөх дээлтэй залуу эр захын өмнүүр гараад зүүн тийш явж байснаа гуйланчинг хараад зогсож, Хуяг уу даа гэж шивэгнэв. Гайхан бодож нилээд ширтсэнээ ойртон очоод “Хуяг минь чи амьд уу?” гэж дуу алдав.)

3. **Эрдэнэ-Итгэлт:** (Явсан хүн зогссон юманд хүрдэг болохоор Эрдэнэ Итгэлтийн том гэрт орж амар мэндийг асуулцан суугаад хийж өгсөн том хул айргийг уух зуур Богдод мөргөхөөр явж байгаад ганц морио хулгайд алдсан тухай яриад айл бараадах унаа гүйв. Та аль хошууны хүн бэ? гэж Итгэлт асуув. Эрдэнэ хэсэгт түгдрээд худал хэлж чадсангүй хошуу нутгаа үнэн зөв хэлэв. Итгэлт нүдээ түргэн түргэн цавчилж хулгай нүдээр Эрдэнийг ажиглана. «Тайшир, тарлан бүх, тавиаг хар, ноцдог дэгээ гэж Засагт ханы хөх харцууд хэцүү гэдэг дээ. Та намайг танихгүй би таныг танихгүй. Бие биедээ балаггүй салбал дээр байх аа» гэж Итгэлт босов. Танай хошууныхан хэцүү гэлцдэг. Гэвч олон мод өндөртэй, намтай олон хүн сайнтай, муутай байдаг бас тэгээд монгол ах дүү байна ядарсан хүнд туслахгүй яахав. Ер нь иүүд манай хаяанд ирээд бууж орхи гэж оровдсон элэгсэг дуугаар хэлэв. Гачигдаж ядарсан хүн итгэхдээ алархан байдаг болохоор Итгэлтийн энэ үгэнд Эрдэнийн сэтгэл баяр найдвариар дүүрэв.)

4. **Төмөр- Түгжил:** (Түгжил олз хайж яваад энэ ховчид шинэ орсон цасан дээр дорвон морины мортэй тохиолдож, юу ч гэсэн энгийн хүний мөр биш гэж мэдээд мушгин иржээ. Түгжил энэ хулгайчийн морьдыг сүрдүүлж байгаад салгаж орхиё гэж боджээ. - За хө хоёр хар морио өгөхгүй бол чамайг барьж явна даа. Би арван тавны цагдаа байна гэж нүдээ салбилзуулан сүртэй хэлээд босож дайрвал ёврохоор ... ухасхийн дайрав. Юу болсныг Түгжил мэдсэнгүй. Нэг л мэдэхэд нарийхан сураар дангинатал хоньчлон хүлэгдээд хэвтэж байв. ... Түгжилийг хүлэгсээр нь тахилдон өргөж толг хар модны бүдүүн мөчрөөг дүүжлээд дор нь овоолсон гишүүний дэргэд сууж хэт цохилж эхлэв.)

5. **Хуяг -Төмөр ба Түгжил:** (Хуяг Доржийн хэлснээр Богд эзэнд гавьяа мэдүүлэн бичиг өргөөд юу ч олоогүй билээ. Тэгээд хүрэнг гүйлгэ гүйх, түлээ хорөөдөх зэргээр амьдарч байлаа. Засагт ханы хошууны нэг айлд түлээ хорөөдөж байгаад Төмөр Түгжил хоёртой дайралдаж зовлон зүдүүрээ ярьсанд Төмөр нэг хар морио өгчээ. Нохдоосоо янгиа олж тохоод нутаг руугаа гарахад «миний ах Эрдэнэ гэдэг хүн, Сайд вангийн юмуу, Луу гүний нутагт байгаа бололтой. Зав гарвал олж сураг гаргаад байвал зүгээр байна. За тэгээд Өлзий гүйд мэнд хүргээрэй» гэж Төмөр хэлжээ.)

6. **Итгэлт –Павлов:** (Мянга есөн зуун олоон он Хатгалаар дамжиж Ангарын хотоос Павлов гэдэг орос, үхрийн наймаагаар энд иржээ. Түрүүчийн наймаагаа Итгэлттэй хийж эхэлснээ хойш олз амог ашиг хонжоо их олж, жил бүр хэдэн зуун үхэр худалдан авч, Түнхэнээр дамжуулан гаргадаг болов.)

7. **Эрдэнэ –Петр:** (Павлов хэдэн жилийн өмнө Луу гүний нутагт гурван том өрөөтэй модон байшин, том хааша барьж авснаас хойш эхиэртэйгээ ирдэг болжээ. Нутгийнхан оросын суурин гэж нэрлэдэг тэр хааша байшинг өвөл нэг орос сахиж үлддэг бөгөөд сүүлийн хоёр жил ашиг Петр гэдэг хочтой болсон ханхар орос сахидаг болжээ. ... Эрдэнийг тэрэгний дэргэд очиход өмнөх өндөр суудал дээрээс ширэвгэр шар сахалтай хонин бор нүдтэй толгой нүүцэн орос бууж ирээд тойрон байгаа хүүхдийг харж арзайн инээмсэглэсэнээ монгол хэлээр Эрдэнэтэй мэндлэв.

Б.Мөнхбаяр

- Танай шинэ байх аа? Би танихгүй байна гэж ашиа Петр ажиглаж байснаа Эрдэнээс асуув.
- Тийм. Би саяхан ирсэн гэж Эрдэнэ хариулаад сууж айраг хийж авлаа.)

8. Төмөр – Дулмаа: (Модон дотор морио уяад тамхи татаж суутал хэсэг хонь хариулсан Дулмаа модны захад хүрч ирлээ. Хоньчин хүүхэнтэй уулзаж Эрдэнийхийг заалгадаг юм билүү гэж бодож байтал хүүхэн дээр сайхан хээр морьтой хүн ирэв. Төмөрийн нүд хээр морин дээр тусав. Түгжэлтэй явж хөөсөн адуунд байсан хээр морь мөн ажээ. Бас морины эзэн нь Бадарч гэдгийг танив. Бадарч Дулмааг олон удаа оролдсон боловч үргэлж ямар нэгэн саад тохиолдоод хүсэлдээ хүрч чадаагүй билээ.

- За Итгэлтийн гэнэн хонгор сайн байна уу?
- Сайн. Та сайн уу?
- Олон амрагтай сайхан хүүхний амтыг үзье гэж ирлээ. Болох юм байгаа биз дээ.
- Дуртай хүнд эдлүүлж байдаг бие надад алга.
- Итгэлт, Цамбад хайрлаж болсон биеийг надад хайрлаж болох байлгүй дээ. Би хүнээс өөр хүн биш гээд бууж очиход нь Дулмаа эргэн гүйж мориндоо мордох гэтэл Бадарч барьж авлаа. Гэтэл Бадарчийн мөрөн дээрээс хүчтэй гар угзран татахад эргээж харвал Төмөр зогсож байв.

... Бадарч ... ум хумгүй давхин алга болов. Дулмаа замбараагүй болсон үс гээг, дээл хувцсаа засаад идэж байгаа морио цулбуураас нь барьж авла.

- Та их ачтай хүн байна
- Төмөр том цагаан шүдээ яралзуулан инээмсэглээд «чоно хонь барьж бийхад салгадаг байхад хүн барих гэж байхад салгахгүй яахав» гээд Дулмаа руу харлаа.)

9. Эрдэнэ-Гэрэл: (Эрдэнийн хувьд гэвэл Шумшаагийн арга огт явцгүй ажээ. Гэхдээ Эрдэнэ уг залыг мэдсэнээс биш, харин «хятадаар ганц үг хэлж чадахгүй намайг бодвол муу муухай ч гэсэн яриад л байна даа» гэж бодоод ихэнх үгүүдийг ажиггүй сонсон, зарим дэндүү буруу хэлснийг нь засаж өгнө. Тэдний хаалгаар Довчин бэйс ёстой л нүдийг нь бүлтэртэл гоёсон залуу эхнэр Гэрэлийнхээ хамт орж ирлээ. Эрээн, цоохор олон өнгийн гэж байгаа шүү дээ гэж Эрдэнийн хэлсэн үг яг дэргэдүүр нь өнгөрч байгаа Гэрэлд сонсогдлоо. «Ямар сайхан дуутай хүн бэ» гэж Гэрэлд бодогдоод эргээж харлаа. Бүр сүүлдээ энэ хүнтэй ямар нэгэн чухал юм ярих гэж энд ирсэн мэт бодогдоод, юу ярихаа бодож олох гэж баахан сандрав.

- Нэг арьс ямар үнэтэй байдаг юм бэ?
- Янз бүр л байна даа гээд Эрдэнэ дүрлэгээр нүдээр харахад Гэрэл өөрийн эрхгүй инээмсэглэв.)

10. Эрдэнэ – Дулмаа: (- Дулмаа минь чи ямар завхай юм бэ. Орооны гичий биш дээ гэж Эрдэнэ тэсээнгүй хэлж орхив. Дулмаа гайхан харснаа тас тас гэж шал худал инээгээд «юу болов» гээд цааш эргэн ажиллав.

- Ёсолж авсан эр нөхөртэй байж тэр асман ламтай юу болоод байдаг юм бэ? Хүнд чинь ёс дэглэм гэж байдаг юм шүү гэж Эрдэнийн хэлэхэд Дулмаагийн нүд нь галзуу үхрийн нүд шиг гөдрөн зангирч, барьж байсан шилбүүрээ газар шидэж, хэмхийгөө зуун ойртож ирснээ:
- Өөрийнхөө эхнэрийг захирч байгаад намайг захираарай гээд шууд эргэжээ.
- Бузарэм, хүнгүтгэнэгэнээ гээд үсрэн очиж Дулмаагийн мөрөн дээрээс барьж авлаа. Дулмаа эргээж Эрдэнэ рүү тогтонгуй бөгөөд хорсолтой нүдээр харснаа зүрх зүсэм хүйтэн инээмсэглэж
- Эхнэрээ Итгэлттэй завхайраад байхад нүд балай, чихэн дүлий болоод сууж байдаг мөртлөө

Б.Мөнхбаяр

миний явдалд оролцоно гэнэ. Аялвал дээр байхаа гээд мөрөө угз татан цааш явлаа. Эрдэнэ Дулмаа хоёрын яриа сонссон Долгор бутанд шахуулсан туулай шиг бүлтэгнэж байв. Эрдэнэ бүх нүүрнийхээ арьсыг хянган хамар дээрээ зангидаж байгаад харахад Долгор гөлөлтөн доош харлаа. - Үнэн үү гэж Эрдэнэ хашиглан асуув. «Худал» гэж эхнэр нь хэлсэн бол Эрдэнэ энэ хорвоо дээр хамгийн жиргалтай хүн болон хувирах байж билээ.

- Үнэн гээд Долгорын нүдэнд нулимс бүрхэв.)

11. Бат- Хонгор: (Аавынхаа тухай өдрийн бодол шөнийн зүүд болж, эцэст нь түүний хойноос явахгаар хатуу шийдээд Хонгорыг хамт явъя гэхэд «өвгөн чинь аав ээж, дүү эд хөрөнгөө хаяад явж болохгүй. Харин чамд тус болъё» гээд зургаан сонгом хайдаг, хэдэн дугуй гэвч ламаас хүлгийн авч өгсөн бөлгөө. Тэгээд салахдаа Булган уулын өвөрт ургасан хоёр моносны дэргэд очиж, үдгэрт гардгийг дууриан нэг нэгээр хуваарилан аваад «азтай сайн явбал мод минь цэцэглэж байг, муу явж доройтвол навч цэцэг нь унаж хувхайраг. Том болоод уулзахгүй бол хэн амьд маань ирж үзэж байна» гэж ярилцсан билээ.)

12. Эрдэнэ-Гэрэл: (Эрдэнэ ... явсаар найм дахь өдрийн үд өнгөрөхийн үед хүрээний зах руу орж ирлээ. Хаа хоргодох юу хийж амьдрах билээ гэж бодсоор гайхан сажилж явтал «Эрдэнэ гуай» гэж эмэгтэй хүн дуудах шиг болов. Цочин харвал хэдэн алхмын тэртээ алд сувд, магнаг гуравт дарагдсан залуу эхнэр инээн зогсож байлаа. Хараач нөгөө Довчингийн эхнэр Гэрэл ажээ. Тэмээнээ хүн унахдаа ширхэг үенээс базаад авдгийн адил, орох орон, идэх хоол байхгүй Эрдэнэ морины амьг эргүүлж Гэрэлийн зүг очлоо. ... Эрдэнэ хотод амьдрах гэж ирснээ ярихад «Та манайд бай л даа» гэж Гэрэл хэлжээ. Нэг орой Довчин эхнэртэйгээ ярьж байснаа Эрдэнэ бол гэгээн цагаан өдөр Луу гүний баян Итгэлтийг дээрэмдээд зугтсан оргоодол гэнэ. Тахиолдсон газар нь барьж авиад Луу гүний хоньгуу тамсанд хүрээж сг гэгээн бичиг үзлээ. Оргоодлыг нүүж байгаад мэдэгдвэл дэмий юм болно гэж хэлэв. Эрдэнэ, Итгэлт хоёрын хооронд юу болсныг мэдсэн Гэрэл баяхан бодол болж сууснаа: - Муу дур нь хүрвэл, тахиж байгаа бурхнаа босоо ороолон болгодог, сайн дуриа хөдөлбөл хүн алсан яргачинг бурхан болгодог бишир аргыг мэднэ. Эрдэнийн нэрийг оорчлоод хөдөө мал дээрээ гаргана. Хэн ч мэдэхгүй. Харин баригдах юм бол үхэж орхино шүү гэлээ. Ингээд Эрдэнэ нэрээ өөрчилж Доной болоод Довчингийн хөдөө мал дээр гарлаа.)

13. Төмөр, Дулмаа- Баатар бэйлийн хошууны нэгэн баян: (Зуны дунд сарын арван наймны сар гарахын үед Төмөр болзсон газраа арван хэдэн согоо шиг морь туусаар иржээ. ... Луу гүний нутгаас Дулмааг дагуулан гарч шууд довтлон явсаар хэд хоногийн дараа Биштар бэйлийн хошуунд Төмөрөөс олон удаа хинийг хүртсэн хоёр хөгийн гадна барьж орхисон дөрвөн ханатай гэртээ очжээ. Нутгийн нэгэн баян айлын хэдэн зуун хонь авч харцулав. ... Гэтэл гай болж нэг эр төлөг эрэг рүү унаад үхжээ. Нэгэн өдөр малын эзэн Баян мал тоолохоор хоёр хүн дагуулан ирлээ.

- Өнгөрөгч хавар нэг хундан эр төлөг эрэг рүү нисэж үхсэн. Би оронд нь энэ хонийг тавьчихъя. Дөрвөн шүдтэй юм шүү гэж Төмөр хонь тоолж байсан Баянд хэлэв. - Баяны нүд солби татаж хөмсөг нь эрчлэн зангирснаа «Та нар л тэгж байгаа байх даа. Нас гүйцсэн иргийг минь цусалж орхиод түүнээ булах санаа байна уу? Би малаа гүйж хариулуулдаггүй. Миний малыг хүн гүйж хариулдаг юм шүү» гээд л бууж гарлаа. Төмөр үнэн явдлыг эвээр тайлбарлах гэж янз бүрээр үзэхэд Баян улам бүр ширүүсэж гүйлэнчин түүлэгчинд нь хүрлээ. Ямар нэгэн яришг төвөг болохоос айсан Дулмаа сандран «тэгвэл үүнийг өгье» гэж ганц байдаг эр хонио заасан чинь, зарц нарынхаа аль дөмөг юмыг элдэв аргаар дуйвардаж сурсан Баяны омог улам

Б.Мөнхбаяр

догширч «Та нараас гуйж байгаа биш. Оногдсон буянгаа бачтай гуйланчин нарт идүүлэхгүй гэж байна. Өгье гэнэ шүү. Их гялайлгах нь» гээд Дулмааг түлхэж орхисон чинь ардаа байсан хөгшөөд тээглэн тас гэдрэгээ унав. Төмөрийн нүд галзуу үхрийн нүд шиг дув дугариг болсноо царай нь чинэсэн, өргөн шанаа нь зангиран Баяныг огцом түлхэн үсрэн эхнэрээ тэвэрч авлаа.

14. **Эрдэнэ – Дорж:** (Намрын бүгчим өдөр Эрдэнэ Довчингийн хашаанд байшингийн саравчинд хийх юмгүй сууж байлаа. Арга барагдахдаа Гэрэлийн өгсөн самбуутай янжуурыг байн байн татавч огтхон ч тус болохгүй ажээ.-- Та галаа өгөөч гэж хажууд нь хүн дуугарахад харвал нам зузаан биетэй бор эр уул нь цагаан байсан болов уу гэмээр алчуураар урсан гарч байгаа хөлсөө арчиж байлаа. Энэ бол нөгөө бидний танил Дорж юм. Дорж одоо Хужирбулангийн цэргэд байгаа бөгөөд өнөө өглөө чөлөө авч хүрээнд орж ирээд хэдэн мөнгө олох гэж түлээ хөрөөдөж байгаа ажээ.

--Та түлээ хөрөөдөж амьдралдаг хүн үү? гэж Эрдэнэ асуув. Үгүй би цэргийн хүн. Хэдэн мөнгө олох л гэж түлээ хөрөөдөж явна гэлээ. - уул нь би Луу гүний хүн. Та манай нутгаар явж байсан уу? нутагт хогшин эхминь үлдсэн юмсан. Сүүлийн гурван жил огт сураг гарсангүй гэлээ. -- Эхийн чинь нэр хэн гэдэг юм бол гэж Эрдэнийг асуухад Доржийн нүд сэргэж: -- Буян гэдэг. Хоёр тамирын бэлчирээр нутагладаг. Баян Итгэлтийн хонийг хариулдаг чавганц шүү дээ гээд -- Таны алдрыг хэн гэдэг бол гэж Дорж гүн санаа алдсаны дараа асуув. -- Миний нэр... Доной гэдэг гэж Эрдэнэ түгдчин хэлэн. Үүнээс хойш Эрдэнэ Доржтой танилцав. Дорж цэргийн амьдралын зовлон. Хот газрын ширүүн амьдрал, амьтны түлээ хорөөдөж чавганц охин хоёрын амьдралд тус болдог тухай Манай дарга гоймон Баатар гэж ядуу хүний зовлон мэддэг хүн бий. Бас тэгээд би цавчих, буудих, ялангуяа морин сургуульд овоо болохоор чөлөө өгдөг юм гэж ярьж байлаа.)

15. **Төмөр-Бадарч тахар:** Шөнийн үерт Тамир хөөсрөн буцан үерлэж өглөө эрт хөдлөх гэж байсан гамин хоригдлоо. Нар гарахын үед тэнгэр цэлмэж хурц нар ертөнцийг соёрхов. Нойтон дээлдээ дагжин чичирч, учирсан гарздаа бухимдан гэлдэрч явтал гурван морь хотлоод Өлзийнд очих, дараа нь Долгорттой уулзах тэгээд уулзаж чадаагүй ганц ахынхаа морийг гаргах гэж явсан Төмөртэй яг дайралдав. Түрүүлж таньсан Бадарч нүүрээ буруулан, "Одоо ч Төмөрийн гараас гарахгүй боллоо. Сахиус минь өршөөгөөч" гэж амандаа шивээгэн явжээ. Гэтэл Төмөр давхиж ирээд олно нь хондолдон зогсов.-- Сайн байна уу? -- Сайн та сайн байна уу? гэж Бадарч газар шагайн харуулав. Төмөр өмнөө зогсож байгаа хачин хүнийг ажигласнаа бүдүүн дуугаар ингэж, -Бадарч уу даа? Өршөөлтэй хүн даваан дээр, өртэй хүн зээл дээр гэдэг болж байх шив дээ гэлээ. Гарцаагүй танигдсанаа ойлгосон Бадарч, Төмөр рүү эгц харж -- Тийм байна, Бадарч байна. За яахав уулзаж дээ гэж хэлэв.

-- Чи чинь архи ууж яваад мориноосоо салж бороонд шалба цохиулж орхио юу?

- Үгүй ээ. Гаминд дээрэмдүүлж орхиод явж байна.

-- Гаминд аа! гэж Төмөр сонирхож асуув.

-- Тийм ээ. Чи ч одоо надаас өшөөгөө авах юм байгаа биз дээ? -Ядарч яваа эр хүнээс өшөөгөө авах ягтаа тулсан эр би биш ээ гээд Төмөр мориноосоо буугаад Бадарч руу ойртов.

-- Тэр жилийн цагаан сараас хойш чи бид хоёр золгоогүй байх аа? Юу ч гэсэн золгож орхиё гэж Төмөр хэлээд энэ хоёр золгов.

Тэгээд зэрэгцэн сууж, Бадарч гаминд буу тулгуулан дээрэмдүүлсэнээ сүр бадруулан яриу. ... Хоёул дайраад цохилж орхиё гэв. Төмөр Бадарч хоёр гэмгүй дүрс үзүүлэн сажилж зэрэгцэн явсаар ойртож очмогц моринодоо ташуур огч шийдмээ эргүүлэн дайрав. --За хөө олзоо хуваани даа. Чи буу авна биз дээ гэж Бадарчийг хэлэхэд Төмөр гүн бодол болсон нүдээр ажиглан харснаа.

— Би юу ч авахгүй гээд эргэж мордоод баруун зүг явлаа.)

16. **Эрдэнэ-Бат:** (Бат гадаалах нэрээр гарч, гишжнээсээ тавигдсан нохой илг алга болов. Явсаар хятадын их чөлөөнд хүрч очив. Эзэд нь дүрвэж эзгүй үлдсэн хятад нүүснээс хүрээнийхэн шуудайгаар юм зөөж гүйлдэн байв. Бат үүнийг гайхан, түүнийг сонирхон алмайрч олноос нь сайхан цагаан морьтой монгол хүн мориныхоо хар хурдаар давхиж ирлээ. Тавиад алд газар ирэхэд нь эцгээ гарцаагүй таньсан Бат «Аав аа. Миний аав аа» гэж хашигиртал Эрдэнэ морины амыг залж хойш эргүүлэн улам хурдав. Батыг ор сураггүй алга болсонд сэтгэл нь зовсон Эрдэнэ байж болохоор айл бүхнээр шивиа сураглан олж ядаад хэдэн шавь нартайгаа хамт гудамжинд зогсож байв. Батыг хараад үлэмж баярлан угтаж очоод: -- Иш гэвш минь гэрээ мартсан гэсэр гэгчээр энэ үймээний цагт хаагуур мориж яваад ирэв дээ гэхэд нь: -- Аав. Миний аав... гэхээс өөр хариу хэлж чадсангүй. Хэсэг байж тайвширсны дараа Эрдэнэнд бүх болсон явдлаа ярьсанд: -- Амьд явбал алтан аяганаас ус ууна гэдэг юм. Аивтайгаа заавал уулзана гэж Батыг тайтгаруулав.)

17. **Хуяг-Төмөр:** (Хатанбаатарын цэрэг Улиастайгаас хөдөлж Дөрвөд Далай хааны өөд аялав. Хуягийн захирсан Хатанбаатарын магнын тавин цэрэг цувран явлаа. Хуяг урт биетэй, өндөр цээжтэй сайхан бор морь унаад цэргийн олно явна. Хажуугийн уулнаас хорь шахам адуу хоосон хүн гарч ирээд цэргийг хармагц зогсов. Хуяг дуран авч тэр зүг харснаа «Төмөр гуай» гээд үг сэггүй давхиснаа явдал дундаа «Төмөр гуай би Хуяг байна» гэж дахин дахин хашигирч явсаар ойртон очиж «Төмөр гуай» гээд үсрэн буув. Хуяг Төмөр хоёр дотно нөхдийн ёсоор уулзаж юуны олно золгож тамхилацлав. Тэгээд Хуяг цэргүүдээ буулгаж амруулах зуур Төмөртэй тавтай ярилцжээ. Төмөр бодол болон сууснаа-- 'Энэ морьдыг цэргүүдээ унаа болгож ав' гэж 'эйчт' хэлэв. -- Түг'ээр' ч' бирихгүй' та' өөрөө цэртгт өрөөд бидэнтэй яв гэж Хуяг хүүхдэдээ хэлж байгаа эцгийн дуугаар хэлэв.)

18. **Төмөр-Баатар бэйлийн хошууны баян:** (Орой нь мордоож шууд явсаар Баяны гэрт очиж буув. Хоёр бага хүүтэйгээ хоол идэж байсан Баян, Төмөрийг хармагц гэмт хүн гэдбэлзэнэ, дайрт морь далбилзана гэгчээр «Төмөр минь сайн явж байна уу. За дээш суу. Хоол ид» гэж юу болохоос чичрэн айсан зүрхээ гаднах сайхан зангаар далдлахыг хичээв. -- Чамайг харанхуй модон дотор хүлэж хаяад хээрийн нохойн идэш болгоно доо. Хамт явъя. Явахгүй гэвэл хүчээр авч явна гэж Төмөр тайван бөгөөд хорсолтой дуугаар хэлэв. Төмөр Баяныг дарж агаад эвхэртэл нь хүлэв. Гэвч хоёр хүүхэд нь «аав аа! Миний аагаа. Аавыг минь болиоч» гэж яс янгинуулан чарлаж хүлээтэй эцгийнхээ дээрээс хэвтэв. Сэтгэл зүссэн хүүхдийн дуу, өшөө хорслоор дүүрэн Төмөрийн зүрхийг зөвирүүлэв. Давааны наад руу Хатанбаатарын гол цэрэг цувран орж ирлээ. Намилзан яваа туг хиур нь салхинд тоглож, оглооний нарны гэрэлд зэр зэвсэг нь гялалзан сүртэй бөгөөд жавхлантай ажээ. Төмөр тэр зүг ажиглан харж байснаа «Баатар вантай уулзаж болох болов уу?» гэж асуув.)

19. **Эрдэнэ-Даржаа баатар:** (Гүн цасанд дарагдсан ойн дундуур гарсан нарийхан замаар эцэж ядарсан морьтой ганц хүн гэлдрэн явж байлаа. Газар шагайн явж байгаа энэ хүн бол Эрдэнэ ажээ. Ингэж явж байснаа зогсож буу сэлэм хоёроо цасанд илдэж орхив. Хэсэг явтал ард нь хүн дуугарах илг болов. Эргэж харвал том хүрэн морь унаж, халиун морь хөтөлсөн, хүрэн дээлтэй, том үнэгэн доовуутай хүн ирлээ. Үүрсэн урт бууны ам нь дээш ёрдойн харагдана. Эрдэнэ, зэвсэгтэй хүн мөрдөн ирж явааг хараад юу болохыг хүлээн зогсов. Хараач дээ! Даржаа баатар ажээ. Баатрыг дэргэдээ ирж

Б.Мөнхбаяр

зогсоход «Баатрын амгаланг айлтгая» гэсэнд «сайн, та сайн уу» гэж харцу мэндлэв. -- Чамийг юун хүн юм бол гэж баахан сэжиглээд хойноос чинь нилээд дагалаа. Буу сэлмээ хаяж байхыг чинь ч харж л байлаа. Ийм цагт сумтай буу, иртэй сэлмийг хаяж болдог эд биш дээ гээд мориноос буув.)

20. **Эрдэнэ-Сүхбаатар:** Хоёр хоног яваад гурав дахь өдрийнхөө үдийн хирд Хүдэр харуулд цэрэг элсүүлж байсан Сүхбаатартай учрав. Даржаа угаас Сүхбаатарыг таньдаг болохоор дотно уулзаж Эрдэнийн бүх явдлыг хэлэв.

-- Манай орныг хэмлэж байгаа дайсан олон байна. Хүчтэй ч байна. Зөвхөн Хиагтад арвин мянгагаруй гамин байна. Биднийг устгахаар хүрээ, баруунаймгуудад цагааннамын этгээд хүч хуралдуулж байна. Эднийг зөвхөн буусэлэм хоёроор хөөж болно. Бид нэгэн санаа нийтийн хүчээр зүтгэвэл хүрэхгүй газар, чадахгүй юм байхгүй. Бидэнд оросын ажилчин тариачин нар Зөвлөлт засаг, большевик нам тусална... Бид одоо цөөхөн байна. Гэвч дийлэ гэж Сүхбаатар ярилаа.

21. **Эрдэнэ-Дорж:** (Энэ хүнийг тавьтдаа авч сургууль хийлээ. Буу зэвсэгтэйгээ хүн шүү гэж Сүхбаатар орж ирсэн хүнд хэлэхэд нь Эрдэнэ, Петрийн тухай бодлоос салж харвал Дорж зогсож байв.-- Доной сайн байна уу?)

-- Сайн, мэнд амгалан уу? Сүхбаатарын хөмсөг нь зангиран Эрдэнийг сэжиглэлтэй харснаа «Яагаад Доной билээ! Сая Эрдэнэ байсан биш билүү?» гэж асуув. Эрдэнэ сандран бүхий л амьдрал явдлаа нэгд нэггүй тоочин ярилаа. Сүхбаатар байн байн Эрдэнийг ажиглан харж, заримдаа ярьснаас нь лавлан асууж байв.

-Та Долгорт дэндүү хатуу сэтгэл гаргасан бололтой гэж Сүхбаатар хэлэв.

-- Намайг доромжилсон шүү дээ.

-- Хатуу амьдрал, гэмт хэрэг ч хийгээдэг юм шүү! Тэр хөөрхий эмэгтэйн буруу биш ч байж болно. Та сайн бодоорой гээд Сүхбаатар гарлиа. Ингээд Эрдэнэ ардын журамт цэргийн цоохор цэргийн хорооны нэгдүгээр тавьтын цэрэг болжээ.)

22. **Эрдэнэ-Петр:** (Бароны цэрэг хэсэг хэсгээр давшин байр эзэлж эхлэв. Үдээс хойш цагаантан их буугаар хэсэг буудсанаа хэдэн пулемётын галын доогуур давшив. Ардын журамт цэргийн байдал хүнд болж, зарим газраар Бароны цэрэгт шахагдан ухарч эхлэв. Сүхбаатар Эрдэнийн дэргэд ирж нэгэн бичиг өгөөд, хэлэв.

-- Хамгийн сайн морь унаад үүнийг хүргэж өг. Цагаантанд баригдах болбол устгах хэрэгтэй гэж Сүхбаатар хэлжээ. Бичгийг авч мордоод явсаар Дээд Шивээнд ирж зуун гуравдугаар бригадын гурван зуун тавдугаар хорооны штабын манаатай учир явдлаа яриад даргатай нь уулзахаар явлаа. Удсан ч үгүй даргын тасалгаанд орж ёслоод бичгээ гардуулав. Тэр дарга орчуулагчаар дамжуулан уул бичигтэй танилцаж байхад цаад тасалгаанаас шинэлээ нөмөрсөн орос хүн гарч ирээд Эрдэнийг харснаа «Уухай даа. Эрдэнэ. Би чамтай лав уулзана гэж бодож явсан» гээд иүүд ирж номхон зогсож байгаа Эрдэнийг тэврэн авлаа.

--Алиа Петр... амьд мэнд үү, чи минь гэж Эрдэнийн нүд нь том болоод дуу алдав.

-- Амьдаар барах уу. Чамд туслахаар ирээд байна гээд том ногоон нүдээ эргэлдүүлэн бүдүүн дуугаар инээв.

23. **Эрдэнэ-Павлов:** (Энэ байлдаанд оролцсон монголын ардын журамт цэргийн дотор Эрдэнэ явалцсан бөгөөд цагааныг зугтахад мориндоо мордон нэхэв. Хэсэг явтал өмнө нь хүрэн морьтой цагааны дарга жижиг буугаар эргэж буудсаар давхиж явлаа. Нилээд хөөцөлдөвч

Б.Мөнхбаяр

зай нь ойртсонгүй морийг нь буудаж орхивал дээрх хүн нь тэртээ хол тонгорцоглон улав. Мориноосоо салахдаа буугаа алдсан Павлов босож ядаж байтал Эрдэнэ давхиж ирээд үсрэн бууж буу тулгав. Павлов гараа алгуураар өргөн зогсов. Эрдэнэ, ажиглавал хөлс шороо болсон нүүртэй энэ орос бол өөр хэн ч биш нөгөө Павлов байжээ.

-- Эрдэнэ гээд Павлов гараа буулгаж өмнөөс нь явах гэхэд «зогс» гэж Эрдэнэ зандрав. Павловын магнайгаас цус урсан хөлс шороотой зууралдан хар хүрэн болоод хацар руу нь урсаж байлаа. «Эрдэнэ минь, бид хоёр эртний танил. Чи миний эхнэр хүүхдийг танина. Амь оршоо!» гээд үйлж гарлаа. Эрдэнэ гайхан зогсов.)

24. Петр-Павлов: (Жамбал явган гүйж явтал хойноос нь ирсэн Павлов морины амыг татаж зогсоод тэр хоёр сундалдан цааш давхилаа. -- Нэг бол улаанууд энэ хорвоо дээр амьдарна. Эсхүл би амьдарна. Бидэнд нэг нар байхгүй гэж Павлов шүдээ зуун хорсон ярьж явахад Жамбал дуугүй: «Энэ оросыг барьж улаанд тушаавал зөвхөн амьд гарахаар барахгүй гавьяа шагнал хүртэнэ» гэж бодож явлаа. Павлов бие засахаар суух үед Жамбал бууны бөгсөөр цохиж ухаан алдуулав. Янгинатал хүлж аваад сууж байтал Павлов ухаан ороход нь шууд өргөн аваад эмээл дээгүүр хондлон тавиад морио хотлон эргэж явлаа. Павловыг Петр байцааж байхад Эрдэнэ дэргэд нь байжээ. Хэнтэй учирсан, юу болохоо сайн мэдсэн Павловын нүдэнд нь үхлийн шийдсэн галзуурал оволзон «Чамайг Тамирын голын бургасанд буудаж орхилгүй, тэжээж байсандаа харамсаж байна» гэлээ. -- Биднийг алаад та нар барахгүй байсан шүү дээ. Хонгор минь гэж Петр тайван хэлэв. - Их Оросын аль олистойг та нар баллаж дууссан улс. Та нарт хайрлах харамлах юм байхгүй. Намайг бууцуу буудаад аль. Намайг амиа гуйна гэж горьдож байна уу. Хол байна гээд Павлов, Петрийн нүүр рүү нулимлаа. Петр ханцуйгаараа нүүрээ арчсанаа -- Бидний шинэ орос улсыг үзэх хувь тавилан чамд байхгүй. Амь гуйхын хувьд бол тэвээ ч чамайг оршоохгүй гэлээ.

25. Дулмаа-нэгэн айл: Удахгүй эргэж ирнэ гэсэн Төмөр хоёр жил гаруй болоход ирэх нь битгий хэл, сураг ч гарсангүй. Ганц эмэгтэй хүн, тэгээд гоо үзэсгэлэнтэй бол хэн зүгээр байлгах билээ. Дулмаа алгуур босоод ороо засах гэтэл нохой нь хуцав. Хэдэн морьтой хүн ирж яваа чимээ сонссон боловч Дулмаа гарсангүй.

- Нохой хорио гэж шахмал бүдүүн дуугаар хүн хэлэхэд аргагүй тарлаа. Баяны хүү хоёр залуу хар хүнтэй орж ирлээ. Баяны хүү Дулмааг шууд барьж авлаа. гурван залуу эрийг яаж гэтлэх билээ. Дулмаагийн хашгирсан дуугаар айлын нь хоёр хөгийн орж ирснийг гурван залуу хүчээр хөөж гаргалаа. Ингээд Дулмааг хүслээрээ доромжлоод явахдаа «дахиад олон ирнэ шүү. Гурав багадаад байвал дөрвүүл ирж болно» гээд доромжлон инээмсэглэв. Дулмааг эндээ зайлахаас өөр аргагүй болов. Хэдэн малаа хоёр хөгийн дэх орхиод хоёр морьтой хөдлөв. Хүйтэн шөно айлгүй газар морио идүүлэн чичрэн дагжиж хонгоод өглөө цааш явахад эцсэн морь нь улам ядарсан байхад чирч гулдарсаар арий ядан явж нэг айл дээр ирлээ. Овоо малтай энэ айлын эзэн Дуламын яриаг сонсоод ганц эмэгтэй хүний зовлон зүдүүрийг хуваалцан, сэтгэл нь их л хөдөлсөн байдалтай байлаа. Ядарч яваа хүн, нүүр өгсөн хүнд итгэх нь амархан байдаг болохоор явах газаргүй болсон Дулмаа тэр айлд бийх болжээ.

26. Дулмаа-Төмөр: (1921 оны зун. Дулмаагийн нөхрийн ахынх ортоон оногдоход Дулмаа нөхөртэйгөө хамт очжээ. Нэг өдөр баруун зүгээс олон цэргүүд ирлээ. Энэ бол баруун хязгаар дахь цагаантантай байлдаж яваа Хатанбаатар Магсаржавын цэргийн түрүүч байлаа. Хуягийн тавьт гэр майхан хоёрт оржээ. - Бузар цангаж орхилоо. Уух юм олж ирье гээд Төмөр, алсан цагаанаас олзлон авсан жижиг саваа барьсаар майхнаас гарч ийн тийш

Б.Мөнхбаяр

харахад тэртээ хойно том гэрийн гадна зуух татаж галласнаас багширсан хөх утаа манаран харагдав. Дэргэд нь хүрэн дээлтэй эмэгтэй хүн түлээ хагалж байлаа. «Гал байсан газар, ус байх биз» гэж бодоод Төмөр том том алхав. Сав бариад цээжээ үл мэдэг бөхийн ирж байгаа мундаг эрийг ажиглан харж байсан Дулмаа гэнэт «Төмөр, Төмөр минь» гэж хашигираад гүйх гэснээ шургачин унав. Төмөр зогсож ажиглан харснаа «Дулмаа минь, ямар сайхан учрал бэ» гээд гүйн очиж ухаангүй хэвтээж байгаа Дулмааг тэврэн авлаа. Дулмаа Төмөрийн өвөр дээрээс босож зогсоод «Төмөр минь би аргагүй болсон шүү. Намайг юунд мартаж орхив» гэхэд нь нүдэнд нь гомдол, гэмшил хосолж, нулимс хацрыг даган жирэлзэн урсав.)

27. **Эрдэнэ-Довчин, Гэрэл:** (Тэр өглөө Эрдэнэ хүрээний зүг хос морьтой гарчээ. Замдаа онц юм тохиолдолгүй явсаар хүрээнд ирж заасан хүнд нь Сүхбаатарын бичгийг хүргэж өглөө. Хүрээний хувьсгалчид Баронд биеэ худалдсан Довчин бэйсийн тухай жигшин ярилцаж, түүний гарт байгаа нэгэн чухал бичгийг хэрхэн авах тухай ярилцаж байхыг сонсоод «Би тэдний зарц байсан. Довчинг ч гэсэн, эхнэрийг нь ч гэсэн сайн танина. Уул бичгийг салгаж авч өгөхийг оролдъё» гэж Эрдэнэ хэлэв. Үдээс хойш нар ханын элэг өөд гарах үед Эрдэнэ Довчин бэйсийнд очив. Бэйс гэртээ байсангүй. Харин Гэрэл Эрдэнийг ирсэнд үлэмж баярлан: -- Юу болоод ор сураггүй алга болсон бэ. Та чинь хүнийг өрөөддөггүй хүн байна гэж гомдол нэхэн угтлаа. - Энэ үймээний цагт над шиг хүн нэгэн газар удаан тогтож болохгүй байна гэхээс өөр үг Эрдэнэ хэлсэнгүй. -- Довчинд нэг чухал бичиг байдаг юм. Түүнийг бидэнд олж өгвөл үлэмж тус болох байна гэлээ. Орой болж хоол идэж байтал Довчин орж ирээд Эрдэнийг хармагц царай нь барсхийгээд «Аи Эрдэнэ хаанаас гараад ирдэг билээ?» гэж асуув. Эрдэнэ «гаминд баригдаж хатуу ажил хийсээр Бароны цэргийн ачаар суллагдаж ирсэн» гэж яриу. Довчин Эрдэнийн энэ үгэнд үнэмшсэнгүй. Харин түүнийг сэжиглэж байлаа. Орны толгойн жижиг ишрэн дээр тавьсан хавтастай бичиг Эрдэнийн нүдэнд байн, байн тусавч Эрдэнэ сэжиг авахуулахгүйг хичээн байлаа.

- Би ганзай халилгуулсан. Одоо болж байгаа байх. Чи хэлээд авчруул гэж Гэрэлийн хэлэхэд Довчин үг дуугаралгүй босов. Гэвч энэ хооронд хэрэгтэй бичиг Эрдэнийн өвөрт орсноор барахгүй, хашааны хашга дуугаран хэн нэгэн хүн гарах чимээг Эрдэнэ сонсов. -- Одоо би явахгүй бол болохгүй гээд Эрдэнэ хөдлөх гэтэл Гэрэл ойртон ирж нүднээс нь нулимс ундрал гарч:

- Намайг нэг ч болсон үнсээч гэлээ.
- -- Чиний тусыг мартахгүй гээд Эрдэнэ Гэрэлийг чанга тэврэн авч уруул дээр нь үнсээд
- Би амьд мэнд ирвэл уулзана гээд гарлаа.
- Би таныг хүлээе гээд Гэрэл хоцров.)

28. **Бат-Петр:** (Үл мэдэгдэх дуугарч байгаа зүг морьтой явган хүмүүс цувран явааг харахад тэнд ербусын сонин явдал болж байгаа юм шиг санагдаад мань хоёртэсэлгүйгүйв. Энэ бол Богдын хүрээг эзэлж байгаа ардын журамт цэрэг байлаа. - Хүжэ. Зайлъя гээд Бат дахин угзархад Жаргал эргэж: - Өвгөөн тэр хоёр том бүрээг хараач. Хүний биеийг эгээл могой шиг ороосон юм билээ. - Юуны чинь бүрээ. Цаадуул чинь барьж аваад дүүжэ. гэснээ Бат дуугаа тасалж нүд нь ондөр хүрэн морьтой хүн дээр тусан голорч ам нь өөрийн эрхгүй: «Алиа Петр гуай!» гэж чанга бөгөөд огцом хашиграв. Хүрэн морьтой Петр олныг тойруулан харснаа Батыг олж харахын үед Бат дахин «Алиа Петр гуай» гэж хашиграв. Петр морины амьг залан жагсаалаас гарч Батын зүг амаа ангайн инээмсэглэн ирлээ Петр мориноос үсрэн бууж Батын гараас барин:

— Чи Бат байна. Би таньж байна гээд үнсэв.

— Тийм. Би Бат байна.

- Эцэгтэй чинь би заавал уулзуулж өгнө. Одоо чи надтай бай гэж Петрын хэлснийг Бат

Жаргал хоёр зөвшөөрчээ.)

29. Бат-Сүхбаатар: (Жаргал Бат хоёр улаан цэргийн хуаранд хөгжилтэй амьдарч том шинель, саривчтай малгай, шөвгөр хар гуталтай болж билээ. Заримдаа Улиастайн голын айлуудаар хэсэж андахгүй болсноор барахгүй «номхон борын тэжээмэл хүүхдүүд» гэж нэрлэжээ. Өвөлд нь Наймаа хотод өвөлжиж зунд нь Улиастайн голд хэдэн хонь ямаатай зусдаг хоёр хөгшинийд нэг удаа тараг идэхээр очиход гадна нь эмээлтэй сайхан хээр морь сойлттой байлаа. Орвол баруун орон дээр нь цагаан цамцтай, нэг эр цааш харан хэвтэнэ. Гэрийн эзэн өвгөн гадаа хонины хашаа засах бөгөөд авгай нь гэрийн зүүн хоймор юм оёж байлаа. Авгай босож агар хувинтай тараг тавьж өгөөд Жаргал нэг том аягыг гүвдэж орхиод хоёр дахин өмнөө тавьж Бароны цэрэгтэй байлдаж явсан, Бароныг хүртэл буудаж шархдуулсан, нисэж яваа шувууг орос ланжуугаар нэг л бууддаг, манай энэ нөхөр бол сэлэмний эрдэмд хосгүй хүн. Нэг цавчихдаа гурван толгой бөндийтөл нь аваад тээр тэнд өнхрүүлж орхидог эр дээ. Сэлэм эргүүлж байхад бие нь нэг бөөрөнхий хөх юм л харагддаг гэхэд нь - Мундаг цавчдаг эр байна даа гээд орон дээр хэвтэж байсан хүн тачигнатал шээгээд эргэв. - Яаж эргүүлнэ, цавчина гэнээ гээд Сүхбаатар хөгжилтэй шээгээгээ. За тэр буудах цавчих ч яамай. Харин аав чинь сайн яваа даа. Ёстой л цагаантай цавчилдаж байгаа гээд Сүхбаатар хоёр хүүхдийг өхөөрдсөн хошин нүдээр харлаа.

- Аав минь одоо хаана байгаа бол?

- Ханд чин вангийн хүррэн дээр саяхан очсон. Чи аагаа санаж байна уу?

- Аагаа их санаж байна гэж Бат нам дуугаар нэрэлэхгүй үнэнээ хэлэв.

- Аав их санагддаг юм шүү гээд Сүхбаатар гүн санаа алдав. Бат аавынхаа тухай ярих тусам Сүхбаатарын сэтгэлд аав нь орж тодорно.

- Дүү нар минь одоо манайд цавчих буудахаас илүү хэрэгтэй юм байна. Тэр бол эрдэм. Та хоёр эрдэмтэй хүн бол, Удахгүй ардын хүүхдэд ном эрдэм заах оюутан багш нарыг сургах танхимд байгуулах гэж байгаа. Та хоёр тэнд ороорой. Петр комиссар ч надад ярьсан юм даг гэлээ.)

30. Бат-Эрдэнэ: (Өвлийн нэг өдөр Эрдэнэ, Петртэй хамт ирлээ. Хуучин хөх чичүү дээд, цагаан хурган хувин малгай өмсөж модон хүйтэй буу, урт хар хүйтэй сэтэм зүүсэн эцгээ хараад Бат яах учраа олохгүй гайхан зогсож билээ. Эрдэнэ хүүгийнхээ хоёр хацар дээрээс үнсэнээ нүднээсээ гарсан нулимсыг алгаариа арчив. Эрдэнэ, Батыг бодоходоо урьдын бага бандиар нь дүрслдэг байсан. Гэтэл одоо түүний өмнө том биетэй ханхар хар хүү зогсож байсан тул нэг бодоход үлэмжийн дотны хүн шиг, нэг бодоход аль нэг газар хальт харсан таних, танихгүйн хоорондох хүн шиг байлаа. Бат аавыгаа хараад бас л хоёрдмол сэтгэл төрнө. Өмнө нь зогсож байгаа хүн бол хэдэн жилийн өмнө хорвоо дээр хамгийн дотно бөгөөд юм бүхэнд дуурайл болж байсан аав бий мэт учраас бишүүрхэх сэтгэл буй болно. Гэвч харах тусам олон жилийн турш зүүдлэн бодож, хүсэл мөрөөдлийг эзэлсэн аагаас нь оор хэн ч байж боломгүй ажээ.)

31. Бат-Төмөр: Энэ цуваа аажмаар явсаар Чойжин ламын сүмийн ариар гарч ирэхэд Бат Жаргал хоёр чихэлдэн зүтгэж явсаар олны өмнө гарч зогсов. Төмөрийг олж харсан Батын нүд дув дугариг болсноо «Төмөр ах аа. Ах аа!» гэж байдаг чадлаараа хялтиулан хаширсан нь олны анхаарлыг татлаа. Түргэн очихгүй бол нүдэнд нь туссан Төмөр алга болчих юм шиг бодсон Бат гүйн очиж түүний цялбууриаа барьж авахад морь нь үргэв. Салан сарнисан улсын уулзалт шиг сайхан юм энэ орчлонд юу байх билээ. Энэ учрал нь хагацал гашиуудлаар дүүрсэн Батын сэтгэлд баярын хүр, жаргалын цэцэг буй болгов.

Б.Мөнхбаяр

Баярласан сэтгэл нь барьцгүй гуд татуулсан бөхийн гар шиг бүхнээс тэмтэрч уйлах, инээх зэрэгцэн сарвалзана. Төмөр Дулмаа хоёр Хуягтай нийлэн мөн л нэгэн ханхай гэрт бууж билээ. Гэвч эмэгтэй хүнтэй гэр хэдэн цагийн дараа бүлээ бутарсан орон болжээ. Дулмаа нь Төмөр ахын нь эхнэр болжээ гэдгийг Бат дор нь ойлгосон боловч энэ хоёр яаж яваад хэрхэн суусныг яаж мэдэх билээ. Мэдэхийг ч төдий л хүссэнгүй. Ижийнхээ тухай Нямаас сонссон тасархай боловч хатуу үгийг Бат нулимсаа дуслуулан ярихад «Дүү минь хорвоо гэдэг хэцүү юм даа. Нэгэнт өнгөрсөн хойно уйлаад босох биш» гээд Дулмаа өөрөө уйлав.

32. **Долгор-Баяр Дэжид:** (Хэдэн жилийн өмнө урд Тамирын бургасанд өвөлжиж байхад энэ нэг явдал болсноос хойш Баярынх ам гурвуулаа болжээ. Нэг өдөр Дэжид авгай бургас түүгээд голын захаар явж байтал усны ногоо талаас хөх дээлтэй толгой нүцгэн эмэгтэй хүн ирж явлаа. Энэ бол Долгор байлаа. Долгор шууд явсаар уур сивссан харз руу ороод гар нь хоёр дахин гялалзан мөсөн доогуур далд орж билээ. Дэжид гуай дуу алдан хашгирч эмэгтэйн орсон харзаас арваад алхам байгаа хөлийн цоорхойд гүйн очтол ухаангүй болсон Долгор хайргадан урсгаж ирэхэд нь хормойноос нь барьж авлаа. Дэжид гуайн сандарсан дуугаар ойрхон шиг бургас огтолж байсан Баяр гуай сандран ирж хоёр хөгшин Долгорыг дамжлан гэртээ авчраад биенээс нь хувцас хунарыг нь салгаж хэсэг зуур түрүү ураги нь харуулан хэвтүүлжээ. Хамар алмаас нь ус баахан гоожиж байснаа амьсгаа ороход нь үзүүрсэн нэхий дээлд битүү ороожээ. Шонь нь бүр ухаан орсон боловч халууран хэдэн сар үлгэн салган өвчтэй байлаа. Алдаг оног хоолтой байсан боловч сайхан сэтгэлт хоёр хөгшиний асралтын ач, өргөлтийн сайн, залуу чийрэг биеийн хүчээр хавар нь тэнхээ тамир цог жавхаагүй боловч эрүүл хүн болжээ. Зун нь бүр тэнхээ орж Баяр, Дэжид хоёрт төрсөн үр шиг нь хайрлагдан, тэдний бүх хөрөнгө нь болсон хоёр сарлаг, нэг хайнагийн шарыг бөөцийлөх ажилд тусалдаг болжээ)

33. **Долгор-Итгэлт:** (Долгор хүү минь эргээд хараач гэж Эрдэнэ ирлээ гэж андуурсан Дэжид гуай хэлэхэд Долгор эргэвэл нүүд нь дугараг болсон Итгэлт зогсож байлаа. Долгорын нүүд хорслоор дүүрч гөлөрсөнөө амьтан руу гэтэж байгаа шилүүс шиг биеэ хураан хөлөө алгуурхан зөөж явсаар Итгэлтэд бараг тулж очоод «Миний зөвлөнд чи бас цадаагүй юу» гэхэд Итгэлт худлаа ингэмсгэлэн «Чи минь юу болж байна. Амьд уулзсандаа баярлах ёстой биш үү? Юу ч гэсэн золгоё» гээд гараа сарвайхад Долгор хөдөлсөн ч үгүй дуугарсан ч үгүй. Гэвч түүний нүүд чаддаг сан бол Итгэлтийг тасчин идэхээс буцахгүй байгаа сэтгэлийг илчилж байлаа.

— Долгор минь би чиний хойноос Ням гуайг явуулсан шүү дээ. Харин цаад зөнөг чинь хутгаж орхисон. Гэтэл би өнөө өглөө чамайг энд амьд байна гэж сонсоод тус больё гэж ирсэн...

— Уухай, Надаас чамд авмаар юм бас байна уу?

— Иш. Тусалъя. Тус больё гэж ирсэн гээд байна шүү дээ. Итгэлтийн хурц нүүд ингээж байхдаа Долгорыг ажиглав. Урьдын Долгор биш болжээ. Түүний нүүрэнд оргилж байдаг амьдралын гал, идрийн цог жавхлантай болсон авч насжин тогтсон эмэгтэй хүний намбатай гуа үзэсгэлэн буй болжээ.)

34. **Ленин-Сүхбаатар:** Тэр намар Хуяг Сүхбаатарыг дагаж зөвлөлт улсын нийслэл Москва орж монгол зөвлөлт улсын хооронд гэрээ байгуулах ажилд оролцож ирсэн билээ. Энэ учраас түүний ярианы ихэнх нь их багш Ленинийг харсан тухай Москвад үзсэн зүйл, замын хөг байдаг

юм.

35. Эрдэнэ-Итгэлт: (Ардын засгийн төлөөлөгч Эрдэнэ урьд шөнө Луу гүний хошуунд ирээд өглөөнөөс эхлэн нилээд ажил хийжээ. Харин Долгорын тухай хэд хэдэн хүнээс асуух гэснээ сонсох хатуу хариунаас халшраад зүрхэлсэнгүй. Сэтгэлээс нь Долгор салаагүй учраас унтаж ч чадсангүй. Нар ханын элэг оод гарч байхад өртоооний гэрт орж цай ууж байвал гэнэт Итгэлт орж ирээд шууд урт хадаг гарган дээр нь давхарласан мөнгөн янчаан тавиад «Би язгуур угсаагүй суман эр, эрх ялбатныг үзэж чаддаггүй жигшиж байсныг чи сайн мэднэ. Ардын засаг бол миний хүсэж мөрөөдөж явсан засаг мөн. Урьдах төрийн үед элдвээр нүд үзүүрлэгдэж аль олигтойгоо албан гувчуурт өгч явсан бидэндээ туншиг, гэгээн нар минь болсон засаг төрдөө өчүүхэн нэмэр болтугай гэж аюуш хадаг, хоёр зуун мөнгөн янчаан барья. Тогтоон соёрхоно уу» гээд баршаа. Эрдэнэ хадаг мөнгийг авахаас өөр замгүй болов. Эрдэнэ хадаг мөнгийг авч орон дээрээ тавиад эргэтэл Итгэлт «За хоо муугийн ёс биш монголын ёс болохоор золгож орхиё» гээд гараа сунгахад Эрдэнэ ухаараагүй боловч дидаж сурсан хөдөлгөөнөөр золгов. Энэ бүхэнд зоригжсон Итгэлт Эрдэнэд сэхээ өгөхгүйг хичээн гэрийн нөгөө талд гарч суух зуур:

— Бид хоёрын дунд ёозгүй юм болж байсан. Гэвч тэр бол залуугийн гай, ухааны муухгаас болжээ. Эр улсын хооронд юу эс болох вэ. Гэвч эвдрэх нэг өдөр байхад эвлэрэх нэг өдөр байдаг шүү дээ. Бид хоёрт Долгорын хувьд их нүгэл хийсэн улс даа гэлээ. «Долгор» гэдэг үг Эрдэнийн занал хорслыг дахин оволзуулж хоёр гар нь зангирав. Итгэлт ашгүй доош харан:

— Чамайг явснаас хойшихон Долгор Заяын хүрээ ороод алга болсон. Нас барсан гэж ярьцагаасан. Гэтэл урьд Тамирын голд амьд мэнд байна билээ. Гэтэл Эрдэнэ үгийг нь таслан:

— Юу гэж хачин зэвхий дуугаар асуув. Итгэлт Эрдэнийг харж ингэмсэглэх мэт болсноо:

— Би Долгорттой дайралдсан. Нөгөө мань Ням гуай л талийгаач болсон гэж амьтан үймүүдсэн хэрэг. Намайг хараад шууд хөөсөн, хоорхий амьтан аргагүй шүү дээ. Би ч залуугийн хар гайгаар буруу хэрэг хийсэн хүн, чи ч гэсэн дээ. Үнэнийг хэлэхэд дэндүү ширүүн аймгисан шүү гээд санаа алдаж Эрдэнэ оод харан гунигтайгаар ингэмсэглэв.)

36. Эрдэнэ-Долгор: (Хаваржаандаа буусан Баяр өвгөний гэрийн гаднаас том хүрэн хайнаг хөдлөсөн тэрэг омнох уулын арын модны зүг хөдлөв. Тэргэн дээр хөх дээлтэй Долгор холоо унжуулан суугаад хайнагийн жигд бөгөөд эрмэг алхатанд найган, хагас хоолойгоор урт бөгөөд гунигаар дүүрсэн аятай дуу аялна. Тамирын голын зүгээс бариан морьтой хоёр хүн Баярын гэрийн зүг юманд хөөгдсөн мэт хурдан давхисаар нарийхан голын зүлгэн дээр суугаад шир зүсэж суусан хоёр хүний дэргэдүүр гарах гэснээ нэг нь «тэр байна» гэлээ. Долгор шир зүсэж байсан хутгаа шидээд, хяхарсан дуугаар — Эрдэнэ минь хэлээгүй юу? гэж хашигираад гүйснээ зог тусан зогсов. Эрдэнэ мориноос үерэн буугаад Долгорын омноос том том алхаанд очиход Долгорын нүднээс нулимс асгаран гээрэгээ өөрийн мэдэлгүй унав. Омноос нь ирж явсан хүн яахын аргагүй Эрдэнэ мөн боловч бишүүрхэх эвгүйнцэх сэтгэл бадарчээ. Баяр гуайн бор гэрээс морины аргамжааны зайтай газар Долгор Эрдэнэ хоёр зэрэгцэн сууж ярилцана.

— Би ч чамд эртний Долгор биш, чи ч надад эртний Эрдэнэ биш болж дээ. Одоо ч чи бид хоёрын хамт амьдардаг хөг өнгөрсөн бололтой гэж эцэст нь Долгор хэлжээ.

— Долгор минь. Чи намайг гомдоосон үнэн. Гэхдээ овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ гэж үг байдаг. Чи бодооч бид өнгөрснийг мартаж, ирээдүйгээ бодож амьдарья. Бид хүүтэй шүү дээ.

— Тиймээ хүүтэй гээд Долгор хэсэг дуугүй сууснаа нам тэлүүн дуугаар

— Гэвч гомдож хүүтэрсэн сэтгэлийг хүчилж болдоггүй бололтой. Хүчлэх гэвэл дэлбэрч магад байна. Миний туулсан зовлонг чи сонссон. Гэвч үзээгүй. Маргааш нь аргагүй болсон Эрдэнэ явлаа.)

37. Долгор-Бат: («Хүрээ орж хүүтэйгээ уулзъя» гэж ганц бодол Долгорын сэтгэлээ салахгүй болов. Тэророй Долгор «Хүрээ орж хүүтэйгээ уулзъя» гэдэг бодлоо хоёр хөгшинд хэлж орхив. Хэдэн өдрийн дараа хүрээний зүг том хүрэн хайнаг холлосон цоо шинэ цагаан модон тэрэгтэй Долгорыг хөдлөхөд хоёр хөгшин хээр морин дээрээ сундалдан бариг хагас өртөө газар гаргаж өгөв. Ингээж явсаар Туул голыг гирч Богд хаан уулын аймгийн төвийн захад очиж нэг сайхан зүлгэн дээр буув. Аймгийн төвөөс нэг сайхан бор морь хөтөлсөн ижил зэвхий ногоон дээлтэй хоёр залуу чанга чанга инээлдэн ирж явлаа. Бодвол морио услахаар явж байгаа бололтой. Долгор зогсов. Нүүр нь татвалзан, нүд нь гөдрөн хэн ч үл сонсох тагжирмал сөөнгө хоолойгоор «Бат хүү минь!» гэвч хөдөлж үл чадна. Ингээж хэсэг байснаа гэнэт байдаг хүчээрээ «Бат аа миний хүү. Ижий нь.» гэж ер бусын хохир дуугаар чарлаад дотор нь манаран сууж уйлав. Тийм дээ. Эх хүүгээ буруу танихгүй. Энэ бол яахын аргагүй Бат байлаа. Оюутны сургуулиа төгсөж Богд хан уулын аймгийн танхимын дагавар сургагчаар ирээд байгаа нь энэ билээ. Эхийнхээ дууг сонссон Бат гүйн очив. Ганц хүүгийнхээ толгойг эгэндээ тэврэн аваад энгэнэтэл уйлж байхдаа хорвоо дээр зовлон байвч жаргал бас байдгийг бүх сэтгэлээр мэдэрч байлаа. — Ижий минь битгий уйл. Амьд уулзлаа шүү дээ гэж Бат хэлэвч өөрийн нүднээс нулимс дусална.)

38. Төмөр-Хонгор: (Ингээд өөрөөн дигуултай Төмөрийн зүг хөдлөхөд Заяын жисын донир бүчийг боож өвөртлөөд явжээ. Маргааш нь үдийн хэрд Төмөрийнд очиход хүрэн торгон тэргэгтэй Төмөр нохойгоо хорьж өгөв. Улаан хүзүүвчтэй том халтар нохой бариад Төмөрийн дэргэдүүр гарахдаа «Би Хонгор. Ах минь намайг бодоорой» гэж шивэгнэн хэлжээ. Донир өөрөө уудалж бооболтой бүчийг гарган маш удаан задлан, унжуулж бариад — Та энэ бүчийг таних уу? гэж Төмөрөөс асуув. Төмөр юу ч дуугаралгүй бүчийг аваад

— Танина. Тэгээд юу гэж?

— Энэ бүчийг энэ хархүү цам дээр зүүж яваад баригдсан. Уул нь манай алдсан бүч. Тань дээр буулгаж байна гэж Донир Төмөрийн ширтсэн цог шиг хоёр нүднээс хараагаа зайлуулан, өмнөө байгаа хултай айраг руу гөлөлзөн хэлэв.

— Тийм ээ. Би Хонгорт өгсөн гээд Төмөр бүчийг өвөр дээрээ тавив. Хонгорын зурх цохихоо больж зогсох шиг болон тал бүрээс нь хавчиж байсан хүлэг задран унав.

— Тэгвэл бид гэж Донорын ярих гэтэл Төмөр тасалж

• — Би зургаан сайн морио нэг шонго алдсан хүн. Тэгээд мөрийг нь мөшигж явтал энэ бүч хэвтэж байсан. Нэгийг нь таван мориор өгөхгүй хүлэгүүдээ алдаад оронд нь энэ бүчийг авсан хүн дээ. Тэгээд арга барагдахдаа энэ Хонгорт өгч хүү минь найр, наадамтай олны газар зүүж яваад сэжигтэй харсан хүнийг ахдаа авчирч өгөөрэй гэсэн. Энэ бүч та нарын юм бол миний морьдын орсон нүхийг та бүхэн хэлж өгнө дөө гэж Төмөрийн хэлэхэд Донир цочиж гэдэргэ болов.)

39. Хонгор-Бат: (Итгэлт ганц хүүгээ айл болгох гэж хүрээнд орж ирээд тэр оройдоо баахан архи ууж аваад өглөө эрт босож ижил хөнцөлдөв. Бодсон бүхэн нь үлгэрийн юм шиг бүтэж удалгүй хорь гаруй тэрэг дүүрэн ачаатай болжээ. Үдэш орой дөрвөн морио авч Туул голыг гатлан Чандманийн аманд очиж чөдөрлөн хос хосоор нь хэрж тавиад тохмоо дэвсээд эмээлээ дэрлэн түмэн одтой гүн хөх тэнгэрийг ширтэн хэвтэхэд Хонгорын сэтгэл нэг л сайхан байж билээ. Үүр манхийн цайсан хойно сэрж харвал зүүхэнд нь хэрж тавьсан хоёр морины нь цаана нэг хүн унтаж байлаа. Тэр хүнээс хориод алхмын цаана чөдөртэй хар хээр морь идэж байна. Хонгор босож сунцагаад хэрээтэйдээ болж холдож чадаагүй морьдоо ажиглан хэсэг зогссоноо нар гартал тавьж идүүлэхээр шийдэв. Баруун талд нь идэж байсан хоёр морио

Б.Мөнхбаяр

салгаж тавиад, нөгөө хүний наадах морьдынхоо дэргэд очиж салгав. Энэ үед нөгөө хүн сэрж ондийн Хонгор руу харлаа. Хонгор ч тэр хүнийг ажиглав. Хараач! Багын найз Бат ажээ.

— Бат аа гэж байдаг хүчээрээ хашигираад түүний зүг гүйв. Нэрээр нь дуудаад ирж яваа хүн бол өөр хэн ч биш Хонгор гэдгийг Бат танилаа.

— Бат минь чи чинь хаа газраас гараад ирэв. Амьд мэнд уулзах юутай сайхан бэ? За золгож орхиё гээд гириа сунгав. Хоёр найз үлэмж дотно золгов. Бат сургуулийн хэрэглэл авах тухай ярих гэж дан морьтой хотод орж ирээд хоёр хоножээ.)

40. Эрдэнэ-Данзан: (Явсаар цэргийн яамны үүдэнд очиж хэний дуудсанаар хэн гэгч ирснээ мэдэгдээд шууд Данзангийн өроонд оржээ. Эрдэнийг хармагц Данзан их л дотночлон инээмсэглэж, угтан ирээд гарыг нь хэзээний дотны танил хүн мэт барьж урин зэрэгцэн суугаад асууж самбуутай янжууриар дайлав. Дараа нь төрийн бодлого улам нарийн болж байгаа тухай баахан юм ярьснаа)

— Манай орны эдийн засгийн дорой хүн ам цөөн болохоор бусдын гар харахгүйгээр тогтсон байж чадахгүй. Ялангуяа хятад улсын хувьд ухаантай бодлого явуулахгүй бол тун хэцүү. Хятад бол том ч улс, чадалтай ч орон. Хэзээ нэгэн цагт гамингийн гунигт явдал дахин нэмрэн ирвэл улс гэр тогтохгүйд хүрнэ. Бас манай ард түмэн олон зуун жилийн турш хятадын бариа, ялангуяа цай тамхинд дэндүү дасчээ. Нэг өдөр энэ бүхнээр тасалж орхивол ард олон маань хүнд гачигдалд, дутагдал амсаж сэтгэл санаа эвдрэх болно. За тэгвэл яах вэ? Ядахдаа л Хятадын нүүсэнд тавьсан өрийг өгч ая тал засаж найр тавьж хожих чухал мэт гэлээ.

— Тэр өрийг ард түмэн тавиагүй шүү дээ.

— Хэн тавьсан нь хятад улсад хамаагүй биш үү.

— Бидэнд бол тун их хамаатай, бас тэгээд хятадын нүүс олон жилийн турш монголоос хүү авч асар их хонжсоо олоод анх зээлдүүлсэн хөрөнгөө хичнээн дахин өсгөж авсан. Сүүлдээ завишж олсон хүүгээ зээлдүүлж дахин дахин хүү авч байдаг болжээ. Данзан босон тасалгаан дотуурхалхын хэсэг явснаа Эрдэнийн эгц өмнө ирж, гурвалжин ногоон нүдээр ширтэн «Дайраад ирвэл ч яах вэ? Цай тамхиар тасалж орхивол яах вэ» гэж үгээ огцомоор таслан сүртэй асуув. Гэвч Эрдэнэ олон үеийн турш дамжиж байж арай гэж олон тусгаар улсаа цайнаас болж алдах гэсэн Данзангийн үгийг зөвшөөрөхгүй байлаа. Данзан өмдний халаасандаа өрөөсөн гараа хийж «За тантай сайхан ярилаа. Би ингээд өөр ажигтай болохоор удаан ярьж чадахгүй нь» гээд босов. Эрдэнийг гарсан хойно жижижхэн дэвтэр гаргаж хэсэг нэрсийн дотор «Цэцэрлэг мандал, Цогтын Эрдэнэ» гэж бичив. Энэ нэрс бол зэвсгийн хүчээр засаг төрийг авмагц барьж, далд оруулах хүмүүсийн жагсаалт байлаа.)

41. Төмөр-Түгжил: (Төмөр, арслан итг хоёр азаргатай болохоор адуугаа хаидаг ч үгүй манадаг ч үгүй үргэлж тавьж хонодог ажээ. Намрын нэг шөнө Төмөрийн адууг орой бичгээрт гарахаас нь эхлэн модон дотроос ажигж байсан нэг хүн адуунд улам бүр ойртож байлаа. Тэр бол Түгжил гайхал байлаа. Шөнө дунд нилээд өнгөрсөн хойно Төмөрийн ороо хээр гэдэг өндөр бор хээр мориноос бусад морьдыг ногтолж холбон авснаар барахгүй Дулмаагийн найр наадамд унадаг жороо зээрд мөрийг эмээллэж авлаа. Эхлээд баруун урагшаа хэсэг явснаа жижижхэн гол гатлаад эгц урагшаа эргэн Тамирын урд талын өндөр хар уулын зүг довтлов. Төмөр адуун дээрээ очмогц юу болсныг мэдээд ороо хээрээ барьж унаад хүлгэйчийн мөрийг мошигн явж нөгөө жижижхэн голыг гатлав. Жижижхэн даваа давж урт амны эх рүү ороод хэсэг явтал замын хажуугийн хэсэг модноос өндөр улаан хээр морьтой, хөх дээлтэй ханхар эр давхин гарч

— Муу хүлгэйч өвөг аавынхаа гарт ороо биз гэж явдал дундаа хаширав.

Б.Мөнхбаяр

— Төмөр. Заяа нь орхи гэж Түгжил хашигираад хөтөлж яваа морио орхин зугтав. Удалгүй Төмөрийн морины туурай ар шилэнд нь тачигнахад Түгжил эргэн харлаа. Түгжил «Төмөр гуай минь утсын чинээ улаан амийг минь оршоогооч. Яадаг билээ. Өчүүхэн би болъё» гэж хяхарсан дуугаар хашигна. Түгжилийн нүднээс ус асгаран, гар нь хий сарвалзаж «аа, аа...» гэж уул хад янгинуулсан дуугаар хадаан хашиграв. Ташуур Түгжилийн нуруун дээр пин хийж битүү дуугаран буув. Хэдий болсныг Түгжил мэдсэнгүй. Ухаан орж сэрвэл ууц нь хүнд юманд даруулсан мэт өвдөх бөгөөд хажуугийн модноос эмээлтэй морь уяатай харагдлаа.)

42. Солонго-Бадарч: («Бат чинь оорийн гэх морьгүй учраас өнөө өглөө амаа мэдэхгүй эмнэг үрээ унаад явсан. Ийм морьтой бол хаанаас тэгж боогдох вэ. Чи энэ хоёрын нэгийг авч Батдаа өг» гэж сэтгэл нь үглэн гуйж гарлаа.

— Бадарч гуай, та энэ хоёр мориныхоо нэгийг худалдах уу?

— Хорин янчаан тоолвол дуртайгаа мултлаад ав. Ах нь наймаа хийвэл буцдаггүй хүн шүү. Азанд муу байдаг юм.

— Би буцахгүй. Хэсэг цааргалсны эцэст Бадарч хээр морио бөгжөөр тулгаж солиод явахдаа

— Наймаа наанитай, цаанатай байдаг. Буцах гэвэл ах нь хүлээхгүй шүү. Наймааг хийхгүй байж болно. Харин буцаж болохгүй. Азанд муу гэлээ.)

43. Эрдэнэ-Цагаантны гараас аврагдсан хүн: (Өвгөн харснаа нүдэнд баясгалан тодрон угтаж хэд алхсанаа хангуйгаа засаж хоёр гариа сунган <Эрдэнэ комиссарын амгаланг айлтгая. Золгож орхих уу> гэлээ. Эрдэнэ тэр хүнийг таньсангүй. Гэвч сүрхий танимхайрч байгаа энэ хүнд тал өгөн <Таны амгаланг эрье> гэж хариу мэндэлж золгов. Энэ өвгөнийг үзсэн газраа Эрдэнэ бодоод олсонгүй. Тамхиа солилцон, хэрхэн зусаж байгаагаа асуулцаж их л ёсорхов. Эрдэнийг өвгөн хэсэг харж байснаа:

- Та намайг нэг л танихгүй байх шиг? гэлээ.

- Нэг л санаанд орохгүй байна гэж Эрдэнэ үнэнээ хэлэв.

- Довчин бээсийн дээрэмчдэд баригдаад алагдах гэж байхад минь та салгаж өгсөн шүү дээ. Бас хэдэн морьдыг минь дээрэмдсэнийг та л эргүүлж хайрласан. Та хул мориог минь авах гэж юу? Үнэ мөнгө гэхгүй барьчихъя гээд хул мориог тайлан ногтны цулбуурыг Эрдэнэд огов.

- Зүгээр. Би үнээр нь авна гээд Эрдэнэ өврөөсөө түрийвчээ гаргав.

- Авахгүй. Би таны ачаар онгоодор хорвоо дээр тоос хөдөлгөж явна. - Мишй ач биш. Ардын засгийн ач шүү дээ гээд Эрдэнэ инээмсэглэсэнээ мөнгөө гаргаж тоолов.

44. Бат –Хонгор: (Хулгайчийн бүгж байгаа уул ойртох тусам Батын сэтгэл аягүй болж сэтгэл нь доголдон дөрвөн зүг найман зовхисыг хялалзан ажиглаж, байдсаа давирна. Гэтэл хажуугийн модон дотроос сүм шиг гэдэстэй улаан бор морь унасан, бүдүүн ташуур барьсан хүн гарч ирлээ. Удсан ч үгүй тэр хүн Батын ойр ирээд морины амыг татаж ажигласнаа <Батаа ямар сайхан учрал бэ> гэж дуу алдав. Бат нүдээ цавчиж, бүрхээсээ гаргаад харвал цэнхэр торгон дээлийн энгэр заамыг задгай орхиж улбар шар бүс ороогоод наамал ултай шинэ булигаар гутал өшиглөж, цагаан алчуураар толгойгоо ороосон дэгжин эр өөр хэн ч биш. харин багын найз Хонгор нь бийлаа.

- Хонгор... чи юу? гэж Бат хашиграв. Бие биеэ таньсан хоёр найз мориноосоо үсрэн бууж

Б.Мөнхбаяр

өмнө өмнөөсөө инээмсэглэн очиж золгов.

- Чамтайгаа энд учирна гэж огт бодсонгүй шүү. Сайхан аа! гэж Хонгор баяр багтаж ядсан нүдээ гялалзуулан амьсгаадаж хэлэв. Өвгөн чинь өнөө өглөө энэ ууланд сууж байхдаа замаар шинэ татагдсан цэрэг дуу дуулан хөгжилтэй явж байхыг хараад сэтгэл хөдлөөд өдөржин юм бодлоо. Ингээж цасаар унд хийж, цармаар гэр хийж явахын оронд цэрэгт мордъё гэж бодлоо.

- Зөв Хонгор минь. Одоо үед ингээж яваад хэрэг алга. Чи ухаантай сэргэлэн хүн Зөв замаар явбал олонд их тус хүргэж чадна.

- Өвгөний чинь хийсэн хэрэг багагүй болохоор очиход минь барьж аваад гянданд хорьж орхивал яана?

- Буруугаа мэдээд зөв замд оръё гээд өөрөө очиж байгаа хүнийг тэгэхгүй.

- Гэхдээ би хүн алаагүй юм шүү. Энэ ардын засаг гэдэг чинь үгэндээ ямаршуу зорилготой эд вэ дээ?)

45. **Бат-Хуяг:** (Үүр цайхын үед Тамирын эрэг дээр хүрч морио услаад мордох гэтэл өмнөөс ирсэн өргөн замаар хэдэн морьтой хүн хатируулж явсаа харагдлаа. Ажиглавал ардын цэргийн хүмүүс бололтой.

- Юун хүн бэ? Зугтвал буудна шүү гэж тэдний нэг өндөр дуугаар хаширав. Бат хөдлөлгүй зогсов. Буугаа бэлхэн барьсан хүмүүс дэргэд нь ирж учир явдлыг асуусанд болсон явдлаа ярилаа. Дарга нь бололтой нэг хүн, хоёр цэрэгт Батыг <Ангид хүргэж өг> гэлээ.

Бат хоёр цэргийн хамт явж байтал тодөлгүй цагаан давааны замаар жагсан ирж явсан ардын цэргийн ангитай золгов. Төөрч төөрч төрөлдөө гэгчээр энэ ангийн дарга нь Хуяг ажээ.

- Бат чинь аймаг орж пайдах шархай элчтүүд гэж Хуяг хэлэв.

- Үгүй. Би эсэргүү нариаас нохдийнхоо ошоог авна. Яасан ч буцахгүй гэж Бат шийдэмгий хэлэв.

- Эмч ээ. Үүний шархыг боож өг гэж Хуяг тушаав. Тэндээс Бат Хуягийн ангид газарчлан явлаа.) зэрэг болно. Эдгээр уулзалтын өгүүлэмжийг үзэхэд, цөм үйл хэрэг нь онц сонирхолтой, амьдралын чухал агшин, хувь хүний хувь заяаны өөрчлөл, эрс эргэлт, тэр бүр тохиолдомгүй онцгой содон учрал байгаа боловч аль нэгэн уулзалтын тухай өгүүлсэн зүйл нь дангаараа зохиолынхоо гол утгыг илтгэх бололцоогүй. Өөрөөр хэлбэл аль нэгэн уулзалтыг салангид харьцаанд оруулах боломжгүй гэсэн үг. Энэ бол цаашид үл хуваагдах, хамгийн бага, хамгийн анхны үндсэн нэгж болж байна гэсэн үг. Ийм нэгжүүд нь маш тогтвортой, бас өөрийнхөө тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд үүнийг "Хэвшил тогтолцоо (formula)" гэж хэлж болох юм.

Уулзалтын хэвшил тогтолцоогоо цаашид гол ба дагалт, үндсэн ба туслах, суурь ба нэмэлт гэх мэтээр янз бүрээр ангилан задалж, нарийсган хувааж болно. Ийн ангилан хуваах нь тухайн бүтээлийн хэлбэрийн онцлогийг тодхаруулахад чиглэгдэх ба энэ талаас нь харвал жишээ нь "Тунгалаг Тамир"-ын гол баатруудын буй чухал, чухал "уулзалт"-ыг гол хэвшил тогтолцоо, түүнийг нэмэн дэлгэрүүлж тайлбарласан байдалтайг нь дагалт хэвшил тогтолцоо гэж үзвэл эдгээр нь захирч, захирагдах бүтэц, харьцаа бүхий өгүүлэмж үүсгэх аргатай бөгөөд эцэст нь өөрөө, өөр нэгэн төрлийн ондоо хэвшил тогтолцоотой нэгдэн нийлж, нэг зүйл зэрэгцсэн бүтцийг бий болгодог байна. Тэгвэл биеэ даасан хоёр хэвшил тогтолцоо нь харилцан уялдаж, нэгэн зэрэгцүүллийг бүрдүүлэх ба дараачийн уулзалт нь эхний уулзалтдаа захирагдаж, нэгэн харьцаагаар бүтэж байна. Энэ бол "Тунгалаг Тамир"-ын өгүүлэмжийн уялдаа холбоо, хэвшил тогтолцоо (formula)-ны нэгэн хэлбэр нь болно. Хэвшил тогтолцоо нь ийм "амьд" элемент бөгөөд хэвшил тогтолцоог бий болгож чадахгүй бол зохиол бүтээлээ туурвиж чадахгүй байж ч тун магад юм. Тиймээс:

Б.Мөнхбаяр

1. Аливаа хэвшил тогтолцоо (*formula*) нь тухайн бүтээлдээ олонтоо давтагдахаас гадна бусад бүтээлд ч адилхан илэрдэг. Тухайлбал: “Тунгалаг Тамир”-т:

• *Эрдэнэ анх Луу гүний хошуунд ирж буй хэсэг-Итгэлтийг дээрэмдээд оргоод Хүрээ рүү явж байгаа хэсэг*

• *Итгэлт Эрдэнэ-Буян чавганцын уулзалт, мал тооллогын хэсэг- Төмөр, Дулмаа-Баатар бэйлийн хошууны нэгэн баяны уулзалт, мал тооллогын хэсэг. Энд удалгүй мал дутаасан Төмөрийг, хошууны баян хорлон, гянданд суулгаж, Төмөр Дулмаа хоёр салах ба энэ нь Итгэлт Эрдэнийг хорлон, Эрдэнэ Долгор хоёр салж буй явдалтай нэгэн адил болно.*

• *Эрдэнэ Итгэлтийг бараадаж буй хэсэг –Ганцаар хоцорсон Дулмаа нэгэн айлбараадсан хэсэг, Дулмааг нэгэн айлын хоёр хөгишин асарч, дүүтэйгээ гэрлүүлж буй хэсэг-Долгорыг уснаас аварсан Баяр, Дэжид хэмээх хоёр хөгишин ба нутгийн Содном гэгч залуутай суулгаж буй хэсэг* гээд хэвшсэн өгүүлэмжийн тогтолцоо олонтоо давтагдаж байгаа бол “Алтайд” роман, “Гарын таван хуруу” жүжиг, “Малгайтай чоно”, “Солонго” өгүүллэг зэрэг зохиогчийн олон бүтээлээс уулзалтын ийм хэвшил тогтолцоо (*formula*)-ны хэлбэр, загварыг бас харж болно.

2. Нэгэнт хэвшин тогтворжиж тогтолцоо болсон нэгж (*formula*) нь зөвхөн нэг зохиолчийн туурвил зүйн сэтгэлгээний хүрээнд бус нэгэн үеийн уран бүтээлчдийн сэтгэлгээнд түгээмэл илэрдэг. Тухайлбал: Хонгор Төмөр хоёрын уулзалт буюу Хонгорын Цогчин дуганыг ухсан хулгайн хэрэг, түүнийг Төмөрөөр аргалуулж буй байдал, Партизан Дамдинсүрэнгийн ярьсан “Дарлан Банди”¹⁵ хэмээх аман өгүүллэг, урвагч Довчинг Эрдэнэ багалзуурдан хөнөөсөн явдал, Д.Сэнгээгийн “Өвгөн партизаны яриа”, Ч.Лхамсүрэнгийн “Хурандаа” найраглалд бас гарч байгаа нь хэвшил тогтолцоо (*formula*) болсон нэгж нь түгээмэл зүй тогтол болохыг харуулж байна.

3. Энэхүү хэвшил тогтолцоо (*formula*) нь зохиогчийн туурвил зүйн үндсэн хэрэглүүрийн нэг мөн.

4. Тухайн бүтээл дэх хэвшил тогтолцоо (*formula*)-ны нягтралын байдал нэлээд чухал үзүүлэлт болдог ажээ. Хэвшил тогтолцоо нь зохиолчдын уран бүтээлээ бичих үедээ тогтмол хэрэглэдэг мэргэжлийн аргын нэг юм уу?, эсвэл туурвил зүйн гол зангилаа элемент үү? гэдэгт нягтралыг тооцож хариулт өгдөг байна. Нөгөө талаар зохиогчийн уран сайхны сэтгэлгээний хэв маягийг тухайн бүтээл дэх хэвшил тогтолцооны нягтралаар нь тогтоож болно гэж үздэг байна.

Францын судлаач Joseph J. Duggan “Роландын дуулал” (“*The song of Roland, Formulaic 8 Style and Poetic Craft, Berkeley 1973*”) бүтээлдээ: “Роландын дуулал”-д буй хэвшил тогтолцоо (*formula*)-ны цар хүрээ, хэрэглээн давтамжинд нь тулгуурлан хэвшил тогтолцоо (*formula*)-ны нягтралыг 35,2 % байна гэж тогтоожээ. Ингээд аливаа бүтээл дэх хэвшил тогтолцооны нягт нь 20 % -с давбал тэрхүү бүтээл нь **аман уламжлалтай**¹⁶” гэсэн дүгнэлт дэвшүүлжээ.

14. Ц.Дамдинсүрэн “Аман өгүүлэл”, “Академиц Цэцгийн Дамдинсүрэн дурсгалын түүвэр”, ШУА, ХЗХ, УБ, 2008

15 Аман уламжлалтай гэдэг нь хэдийгээр хэн нэгний туурвисан бичгийн зохиол байлаа гэхэд тэрхүү бүтээлээ туурвисан уран сайхны туурвил зүйн сэтгэлгээ нь аман зохиолын хэлбэр байдалтай, аман уламжлалын хүрээнд багтаж байгаа бол ийм бүтээлийг аман зохиол гэж үзэх тухай санал юм. Ийн тогтоох шалгуураа хэвшил тогтолцоо (*formula*)-ны нягт нь гэж үзсэн ба давтамж нягтрал 20% с хэтэрвэл аман зохиол, 20% буюу түүнээс бага байвал бичгийн зохиол гэж үзнэ гэжээ.

Б.Мөнхбаяр

Тэгвэл бидний сонгосон зохиолын Уулзалтын хэвшил тогтолцоо (*formula*)-ны тухайд үзэхэд хамгийн өндөр давтамж бүхий уулзалт нь “Эрдэнийн уулзалт” ба нийт 45 уулзалтын 18 буюу 40%, “Төмөрийн уулзалт” 12 буюу 26.6% байна. Энэ хоёр дүрийн уулзалтын өгүүлэмж нь зохиолын утга агуулгыг илэрхийлэх гол хэсэг нь болж гарч байгаа юм. Тэгвэл Итгэлтийнх 4 уулзалт ба 8.8%-г эзэлж байна.

Эндээс харахад Эрдэнэ нь хэн нэгний нөлөөлөлөөс үүдэлтэй юм уу эсвэл ямар нэгэн хамтын үйл ажиллагааны чиглэл давамгайлсан явдлыг үзүүлсэн байдалтай бол, Итгэлт нь бие даасан үйл ажиллагаа, өөрийгөө илэрхийлэх чадвараар давуу болохыг харуулж байна. Хэрэв хэвшил тогтолцооны сонголтоо зохиолын бүх өгүүлэмжийн хүрээнд хийх юм бол давтамж нь илт нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Өөрөөр хэлбэл зохиолч Ч.Лодойдамбын бүх бүтээлийн хүрээнд хэвшил тогтолцоо (*formula*)-ны сонголтоо хийх юм бол давтамжийн харьцаа нь нэмэгдэнэ гэсэн үг юм. Тухайлбал: Бидний сонгосон эхэд зөвхөн ганцхан удаа гарч буй өгүүлэмж зохиолчийн бичсэн өөр бүтээлд байхыг үгүйсгэх аргагүй юм.

Мөн Ч.Лодойдамба шиг зохиолч одоо цагт ховор, дээр нь ийм нэр хүнд бүхий ахмад зохиолч нар нь орчин үеийн шинэ арга барилаар бичнэ туурвина гэж үгүй, бичдэг зохиол бүтээлийнх нь өгүүлэмж, үйл явдал нь эртнээс хэвшин тогтсон, үгсийн сан нь тодорхой хүрээнд, орчин ахуй нь түүх нийгмийн өргөн дэвсгэр байх ба ийм орчинд л “Тунгалаг Тамир”-ын мөн чанар нь оршдог бололтой.